**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

**ТЕНДЕРИЙН НЭР:** ЭРДЭНЭТИЙН ИЛ УУРХАЙД ГЕОТЕХНИКИЙН ЦОГЦ ХӨТӨЛБӨР НЭВТРҮҮЛЭХ АЖИЛ

**ТЕНДЕРИЙН ДУГААР:** ЭҮТӨҮГ/202202044

ОРХОН АЙМАГ
2022 ОН

# САНАМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгөөс дээш зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ жишиг баримт бичгийг баримтална.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн дагуу гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-т заасны дагуу хэлэлцээ хийж, гэрээ байгуулах эрх олгоно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1-д заасны дагуу бүх тендерээс татгалзсан тохиолдолд хуулийн 30.4-ийг үндэслэн тендерийн баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг оруулж, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулна.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

**I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА** (ТШЗ)
Нэгдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын зааварчилгаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэнэ.

**II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ** (ТӨХ)
Захиалагч нь тендерт оролцогч болон тендерт тавих шалгуур үзүүлэлт, мэдээллийг хоёрдугаар бүлэг дэх тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана. Тендер шалгаруулалтын заавarчилгааны холбогдох зүйл, заалттай уялдуулан хаалт дотор налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг тусгаж тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулна.

**III БҮЛЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**
Захиалагч худалдан авах зөвлөхөөс бусад үйлчилгээний зорилго, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, үйл ажиллагааны хуваарь, гүйцэтгэлийн чанар шаардлагатай бусад мэдээллийг энэ бүлэгт тусгана.

**IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
Энэ бүлэгт тендерийг үнэлэхэд харгалзах бусад шалгуур үзүүлэлтийг тусгана.

**V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД**
Тавдугаар бүлэгт тендерт оролцогч тендер бэлтгэхэд шаардлагатай жишиг маягтууд багтана. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ.

**VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**
Зургаадугаар бүлэгт заасан гэрээний нөхцөл нь гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт, гэрээний хавсралт маягтаас бүрдэнэ. Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэх ба өөрчлөлт оруулах шаардлагатай бол гэрээний тусгай нөхцөлд өөрчлөлтийг тусгана. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон оролцогч болон түүний ирүүлсэн тендерийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад тусгаж, гэрээ байгуулна.

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## ГАРЧИГ


I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) .................................5

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ....................................................................................................5

1. Тендерийн цар хүрээ ................................................................................ 5
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг ..................................... 5
3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ...................................... 5
4. Тендерт оролцогч..................................................................................... 5
5. Туслан гүйцэтгүүлэх болон түншлэлийн гэрээ ...................................... 6
6. Тендерт оролцогч нэг тендер ирүүлэх .................................................... 6

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА .................................................7

7. Тендерийн баримт бичиг.......................................................................... 7
8. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах .......... 7
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт ........................................................... 8
10. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах ................................................................................................ 8

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ .............................................................................................8

11. Тендер шалгаруулалтад оролцох зардал ............................................... 8
12. Тендерийн баримт бичиг болон тендерийн хэл....................................... 8
13. Тендерийн иж бүрдэл ............................................................................... 9
14. Тендерийн жишиг маягтууд .................................................................... 10
15. Хувилбарт санал ...................................................................................... 10
16. Ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай баримт бичиг ............................ 10
17. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг магадлахад шаардлагатай баримт бичиг ... 10
18. Гүйцэтгэх үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг ................................................................................. 12
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт ........................................................ 12
20. Тендерийн валют ..................................................................................... 13
21. Тендер хүчинтэй байх хугацаа ................................................................ 13
22. Тендерийн баталгаа ................................................................................. 14

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ....................................................................................15

23. Тендер баталгаажуулах, илгээх .............................................................. 15
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа ........................................................ 16
25. Тендерт өөрчлөлт оруулах, тендерийг буцааж авах.............................. 16
26. Тендер нээх.............................................................................................. 16

Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ...............................................................17

27. Нууцлах..................................................................................................... 17
28. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах............................................. 17
29. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх ................................ 17
30. Тендерийг үнэлэх...................................................................................... 19
31. Нэг валютад хөрвүүлэх ........................................................................... 19
32. Арифметик алдааг залруулах .................................................................. 19
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох ............................................. 20
34. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх ................................................... 21
35. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах...................................... 21

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ................................................21

36. Мэдэгдэл хүргүүлэх ..... 21
37. Гэрээ байгуулах эрх олгох ..... 22
38. Гүйцэтгэлийн баталгаа ..... 22
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах ..... 22
Ё. БУСАД ..... 23
40. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол ..... 23
41. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт ..... 23
42. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх ..... 23

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

**1. Тендерийн цар хүрээ**

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу тендерийн өгөгдлийн хүснэгт (цаашид "**ТӨХ**" гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон зөвлөхөөс бусад үйлчилгээ (цаашид "**үйлчилгээ**" гэх) авах тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг ТӨХ-д заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг ТӨХ-д заана.

1.3. Тендерт оролцогч багцтай тендер шалгаруулалтын хэдэн ч багцад тендер ирүүлж болно.

**2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг ТӨХ-д тусгана.

**3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**

3.1. Захиалагч, тендерт оролцогч болон худалдан авах ажиллагаанд оролцогч аливаа этгээд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

3.2. ТШЗ-ны 3.1-д заасан этгээдийн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу нэн даруй мэдэгдэнэ.

**4. Тендерт оролцогч**

4.1. Тендерт оролцогч нь захиалагчаас хараат бус этгээд байна.

4.2. Хэд хэдэн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлэх бол тэдгээрийг хамтад нь түншлэл, тус бүрийг нь түншлэлийн гишүүн гэнэ.

4.3. Хуулийн 9.3-т зааснаар гадаадын этгээдийг оролцохыг хориглосноос бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн аль ч улсын харьяалалтай байж болно.

4.4. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригтой хамаарах улсын этгээд тендерт оролцох эрхгүй.

4.5. Тендерийн баримт бичгийн үнийг төлсөн, эсхүл үнэ төлбөргүй олгох тендерийн баримт бичгийг цахим системээр хүлээн авсан этгээдийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд гэж үзнэ.

**5. Туслан гүйцэтгүүлэх болон түншлэлийн гэрээ**

5.1. Тендерт оролцогч нэг ба түүнээс дээш тооны этгээдтэй туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж болно. Нийт туслан гүйцэтгүүлж болох бараа, ажил, үйлчилгээний дээд хэмжээ нь тендерийн үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.

5.2. Тендерийн дагуу ТШЗ-ны 4.2-т заасан түншлэлийн гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүргийн хэмжээ тендерийн үнийн 10 хувиас дээш байна.

5.3. Түншлэлийн гишүүн тус бүр холбогдох журмын дагуу цахим системээр түншлэлийг баталгаажуулснаар түншлэлийг нэг тендерт оролцогч гэж үзнэ. Түншлэлийн гишүүн гадаадын этгээд бол энэ зүйлд зааснаар баталгаажуулахгүй байж болно.

5.4. Түншлэлийн гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна:

5.4.1. Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байх;

5.4.2. ТШЗ-ны 1.1-д заасан үйлчилгээ үзүүлэхэд түншлэлийн бүх гишүүний хамтран болон тус тусдаа хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байх;

5.4.3. түншлэлийг төлөөлөн зааварчилгаа хүлээн авах, захиалагч болон бусад этгээдтэй харилцах, гомдол, нэхэмжлэл гаргахад төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилсон байх;

5.4.4. нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай заасан байх.

5.5. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээг бичгээр байгуулсан, эсхүл хуульд нийцүүлэн тоон гарын үсгээр баталгаажуулсан байна.

5.6. Туслан гүйцэтгүүлэх гэрээнд заасан туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийн хэмжээ ТШЗ-ны 5.1-ийг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

5.7. Түншлэлийн гэрээнд заасан түншлэлийн гишүүний гүйцэтгэх үүргийн хэмжээ ТШЗ-ны 5.2-ыг зөрчсөн бол захиалагч тухайн түншлэлийн гэрээ, түншлэлийн гишүүний чадавх, түүнд холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

5.8. Түншлэлийн гишүүд болон туслан гүйцэтгэгчийн тоонд захиалагч хязгаарлалт тавихгүй.

**6. Тендерт оролцогч нэг тендер ирүүлэх**

6.1. Аливаа этгээд дангаар, эсхүл түншлэлийн гишүүний хувиар тендер шалгаруулалтад оролцоход зөвхөн нэг тендер ирүүлнэ.

6.2. Тендерт оролцогч, эсхүл түүний түншлэлийн гишүүн нь тендер шалгаруулалтын нэг багцад оролцож байгаа бусад тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай, эсхүл тэдгээрийн итгэмжлэлгүйгээр буюу итгэмжлэлээр төлөөлөх эрх бүхий этгээд нь нэг этгээд бол ТШЗ-ны 6.1-д заасныг зөрчсөн гэж үзнэ.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

**7. Тендерийн баримт бичиг**

7.1. Захиалагч баталсан тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ (цаашид “цахим систем” гэх)-ээр илгээн олон нийтэд нээлттэй байршуулна.

7.2. Тендерийн урилгыг тендерийн баримт бичигтэй нийцүүлж боловсруулна.

7.3. Тендерийн урилга тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.4. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлэг болон ТШЗ-ны 10 дугаар зүйлд зааснаар түүнд оруулсан өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг.Тендерийн өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

7.5. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендерийн баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

7.6. Тендерт оролцогч ТШЗ, ТӨХ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлага болон тэдгээрт иш татсан хууль тогтоомж, журам, зааврыг судалж тендер бэлтгэнэ.

**8. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах**

8.1. Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн талаар тодруулга, нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг захиалагчид гаргаж болно.

8.2. ТШЗ-ны 8.1-ийн дагуу гаргах хүсэлтийг бичгээр захиалагчийн ТӨХ-д заасан хаягаар, эсхүл тоон гарын үсэг ашиглан цахим системээр захиалагчид хүргүүлнэ.

8.3. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга нэмэлт, мэдээлэл авах хүсэлтэй тендерт оролцогч энэ тухай хүсэлтэд тендерийн баримт бичгийн үнийг төлсөн (тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй авсан бол шаардлагагүй) баримтыг хавсаргана.

8.4. Захиалагч тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээллийг холбогдох журмыг баримтлан цахим системд нийтэлснийг хуульд зааснаар бүх сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

8.5. Тодруулга, нэмэлт мэдээллийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч ТШЗ-ны 10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

**9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

9.1. Тендер бэлтгэх явцад үүсэж болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар сонирхогч этгээдийн тавьсан асуултад хариулт өгөх зорилгоор захиалагч тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах бол ТӨХ-д заана. Захиалагч уулзалтад сонирхогч этгээд, эсхүл түүний томилсон төлөөлөгчийг оролцуулна.

9.2. ТШЗ-ны 9.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аливаа этгээдийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

**10. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах**

10.1. Захиалагч ТШЗ-ны 24.1-д заасан хугацаанаас ажлын 10 хоногийн дотор тендерт оролцогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулсан бол сонирхогч этгээд хуулийн 55.1-д зааснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргах боломжит хугацаагаар тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгана.

10.2. ТШЗ-ны 10.1-д зааснаас бусад тохиолдолд захиалагч тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор сонирхогч этгээд өөрийн тендерт өөрчлөлт оруулах боломжит хугацаагаар тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

10.3. Тендерийн баримт бичгийн аливаа өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг болох бөгөөд холбогдох журмын дагуу цахим системд нийтэлснээр бүх сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

**11. Тендер шалгаруулалтад оролцох зардал**

11.1. Тендер бэлтгэх, илгээх, оролцохтой холбогдон гарах бүх зардлыг сонирхогч этгээд болон тендерт оролцогч бүрэн хариуцна. Захиалагч энэ зардалтай холбогдох аливаа хариуцлага хүлээхгүй.

11.2. Сонирхогч этгээд гэрээний үүрэг гүйцэтгэх газар, орчны нөхцөл байдалтай танилцаж болох бөгөөд түүнтэй холбогдох зардлыг өөрөө хариуцна.

**12. Тендерийн баримт бичиг болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын урилга, тендерийн баримт бичгийг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний

доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг ТӨХ-д өөрөөр зааж болно.

12.3. Тендерийн баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендерийн баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба тендерт оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээдээр орчуулуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах баримт бичгээс бүрдэнэ:

13.1.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендер илгээх маягт;

13.1.2. тендер илгээх маягтыг тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.1.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.1.4. тендерт оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.1.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох баримт бичиг;

13.1.6. гүйцэтгэх үйлчилгээ ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.1.7. захиалагч шаардсан бол ТШЗ-ны 22 дугаар зүйлд заасан тендерийн баталгаа;

13.1.8. түншлэл бол ТШЗ-ны 5.4-т заасан түншлэлийн гэрээ.

13.2. Тендерт оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн V бүлэг дэх маягтыг бөглөж ТШЗ-ны 23-т заасны дагуу илгээнэ. Маягтад өөрчлөлт оруулалгүй холбогдох хэсгийн мэдээллийг бөглөнө.

14.2. Тендерт оролцогч цахим системийн холбогдох талбарыг бөглөж тендер илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. ТӨХ-д тусгайлан заасан тохиолдолд тендерт оролцогч хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

**16. Ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай баримт бичиг**

16.1. Тендерт оролцогчтой холбоотойгоор хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан байна. Тендерт оролцогч нь ерөнхий нөхцөлийг хангасан тухай мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь дараах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;

16.2.2. тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт.

16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. гадаадын этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичиг.

16.4. Захиалагч тендерт оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.2, 16.3-т заасан баримт бичгийг тендерт оролцогчоос шаардана. Түншлэлийн хувьд гишүүн тус бүр ерөнхий нөхцөлийг хангах тухай энэ зүйлд заасан баримт бичгийг ирүүлнэ.

**17. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг магадлахад шаардлагатай баримт бичиг**

17.1. Захиалагч нь хуулийн 12.2-т заасны тендер шалгаруулалтад тавигдах санхүүгийн, техникийн чадавхын болон туршлагын хангавал зохих доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоож, тендерийн баримт бичигт тодорхой тусгана.

17.2. Тендерт оролцогч нь хуулийн 15 дугаар зүйлд заасныг гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн

чадавхын талаар захиалагчаас ТӨХ-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Энэхүү шалгуур үзүүлэлт, шаардлагыг нотлох дараах баримт бичгээс ТӨХ-д заасныг ирүүлнэ:

17.2.1. харилцагч банкны мэдэгдэл;

17.2.2. гадаадын этгээдийн хувьд ТШЗ-ны 17.3-т заасан хугацаанд хамаарах санхүүгийн тайлан;

17.2.3. ТШЗ-ны 17.3-т заасан тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайланд холбогдох аудитын дүгнэлт;

17.2.4. ТШЗ-ны 17.3-т заасан санхүүгийн тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын талаарх мэдээлэл[1];

17.2.5. гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох ТӨХ-д заасан бусад баримт.

17.3. Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг ТӨХ-д заана.

17.4. Хууль тогтоомжоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэх үүрэг хүлээгээгүй этгээд нь ТШЗ-ны 17.2.3-т заасан аудитын дүгнэлт ирүүлэх шаардлагагүй.

17.5. Тендерт оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдэл болон тендерт оролцогчид зээлийн эрх үүсгэсэн, эсхүл зээлийн өр төлбөрийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг магадлахад харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

17.6. Тендерт оролцогч нь хуулийн 16 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах техникийн чадавх болон туршлагын талаар захиалагчаас ТӨХ-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Энэхүү шалгуур үзүүлэлт, шаардлагыг нотлох баримт бичгээс ТӨХ-д заасан дараах баримт бичгийг ирүүлнэ:

17.6.1. үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай ТӨХ-д заасан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;

17.6.2. гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТӨХ-д шаардсан бол V бүлгийн Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн мэдээлэл;

---

[1] Даатгалын үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үед холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан борлуулалтын орлоготой дүйцэх шалгуур үзүүлэлтийг тусгаж болно.

17.6.3. гэрээг хэрэгжүүлэхэд ашиглагдах ТӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт) бэлэн байлгах тухай Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ;

17.6.4. тендерт оролцогчийн туршлагыг харуулах ТӨХ-д заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 6, Маягт 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;

17.6.5. техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 17.6-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох ТӨХ-д заасан бусад баримт.

17.7. ТӨХ-д шаардсан бол тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 7-ын дагуу ирүүлнэ. ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан чадавхыг магадлахад энэ мэдээллийг ашиглана.

17.8. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагын өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

17.9. Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. ТШЗ-ны 17.2-т борлуулалтын орлого[2], гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6-д ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг тус тус заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

**18. Гүйцэтгэх үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

18.1. Тендерт оролцогчийн үзүүлэхээр санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

18.2. Гүйцэтгэхээр санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан үйлчилгээний тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

**19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

19.1. Тендерт оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

19.2. Тендерт оролцогч III бүлэгт заасан үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагад тусгасан үйл ажиллагаа, үйл ажиллагааны хуваарьт жагсаасан үйлчилгээний бүх нэр төрлийг үнэлж ирүүлнэ.

---

[2] Даатгалын үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үед ТӨХ-ийн 17.2-т заасан борлуулалтын орлоготой дүйцэх шалгуур үзүүлэлтийг ойлгоно.

19.3. Тендерт оролцогчийн үнийг тусгайлан тусгаж ирүүлээгүй үйлчилгээний аливаа нэр төрлийн үнэ, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тээвэрлэлтийн болон даатгалын зардал, татвар, хураамжийг тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд эдгээр зардлыг багтсанд тооцно.

19.4. Тендер илгээх маягтад тусгасан үнэ нь үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

19.5. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан тендер илгээх маягтад заана. Үнийн хөнгөлөлтийг хэрэглэх нөхцөл, аргачлалыг тусгайлан заагаагүй бол санал болгосон үнийн хөнгөлөлтийн хувь, хэмжээг тендерийн нийт үнээс тооцно.

19.6. Хууль болон ТӨХ-д өөрөөр заагаагүй бол тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. ТӨХ-д үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

**20. Тендерийн валют**

20.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол захиалагч тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

**21. Тендер хүчинтэй байх хугацаа**

21.1. Тендерт оролцогч ТШЗ-ны 26 дугаар зүйлд заасны дагуу тендер нээснээс хойш хэд хоногийн хугацаанд өөрийн тендер хүчинтэй байхыг тендер илгээх маягтад заана. Тендерт оролцогч тендер хүчинтэй байх хугацааг заагаагүй, эсхүл 30-аас бага хоногоор тогтоосон бол тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ.

21.2. Эрх бүхий этгээдээс тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацааг зогсоохоор шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

21.3. Хуулийн 29.4-т зааснаар тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг бүх тендерт оролцогчдод хүргүүлнэ.

21.4. Тендерт оролцогч ТШЗ-ны 21.3-т заасан хүсэлтийн дагуу тендер хүчинтэй байх хугацааг сунгах эсэх мэдэгдлийг бичгээр болон цахим системээр тоон гарын үсэг ашиглан захиалагчид хүргүүлнэ.

21.5. Тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 22 дугаар зүйлд заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил сунгагдана.

21.6. Тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрхтэй. Хэрэв татгалзсан бол түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.

21.7. Урьдчилсан худалдан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж буй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## 22. Тендерийн баталгаа

22.1. Захиалагч ТШЗ-ны 2.1-д заасан төсөвт өртгийн 1-2 хувиар тооцсон тендерийн баталгаа ирүүлэхийг ТӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч тухайн үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй үүрэг гүйцэтгэх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан ирүүлнэ.

22.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 22.1-д зааснаар ирүүлнэ.

22.3. Тендерийн баталгаа нь V бүлгийн Маягт 2-ын дагуу Монгол Улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа, эсхүл Маягт 3-ын дагуу Засгийн газрын бонд, Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болох ба ТШЗ-ны 14 дүгээр зүйлд зааснаар бэлтгэсэн байна.

22.4. Гадаадын хуулийн этгээд гадаадын банкны баталгаа гаргуулсан, гадаадын болон Монгол Улсын хуулийн этгээд гадаад улс дахь эрх бүхий этгээдээс Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаас хэлбэрээр тендерийн баталгаа гаргуулах бол дараах шаардлагыг хангасан байна:

22.4.1. тендерийн баталгааны эх хувийг ТШЗ-ны 12 дугаар зүйлийг баримтлан бэлтгэсэн орчуулгын хамт холбогдох журамд зааснаар захиалагчид хүргүүлэх;

22.4.2. баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заасан байх.

22.5. ТШЗ-ны 22.4-т зааснаар гадаад улс дахь эрх бүхий этгээд баталгаа гаргаснаас бусад тохиолдолд тендерийн баталгааг холбогдох журамд зааснаар цахим системээр хүргүүлнэ.

22.6. Тендерийн баталгаа нь ТШЗ-ны 21 дүгээр зүйлд зааснаар тендерт оролцогчийн тогтоосон тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

22.7. Тендер шалгаруулалтад шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааны ТШЗ-ны 22.6-д заасан хугацаа дууссан, эсхүл захиалагчийн гэрээ байгуулсан тухай мэдэгдэлд үндэслэн баталгаа гаргагч тус тендерийн баталгааг хүчингүй болгож болно.

22.8. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

22.9. Захиалагч ТШЗ-ны 38 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа хүлээн авч, ТШЗ-ны 39 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсны дараа бүх оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдэл гаргана. Уг мэдэгдлийг цахим системээр баталгаа гаргагчид хүргүүлнэ.

22.10. Баталгаа гаргагч нь тендерийн баталгааг улсын орлого болгосон мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн холбогдох дансанд, Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэр дээр тус тус шилжүүлнэ.

22.11. ТШЗ-ны 21.6-д заасны дагуу тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан бол захиалагч тухайн тендерээс татгалзаж, тендерийн баталгааг чөлөөлнө.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

**23. Тендер баталгаажуулах, илгээх**

23.1. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг баталгаажуулан тендер шалгаруулалтад илгээнэ. Үүсгэн байгуулагдсан улсын хууль тогтоомжоор шаардаагүй бол тамга, тэмдэг дарахгүй байж болно.

23.2. ТШЗ-ны 23.1-д заасны дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулсан тохиолдолд итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

23.3. Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээс итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд нь өөрийн гарын үсэг, эсхүл тоон гарын үсгээр тендерийг баталгаажуулсан байна.

23.4. Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д заасныаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

23.5. Тендерт оролцогч өөрийн тендерийн дараах баримт бичгээс бусад хэсгийг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр нууцалж болно:

23.5.1. ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн бүх баримт бичиг;

23.5.2. V бүлгийн дагуу ирүүлсэн маягт;

23.5.3. ТӨХ-д заасан бусад баримт бичиг.

23.6. Тендерт оролцогч ТШЗ-ны 23.7-д зааснаас бусад тохиолдолд тендерийг бүхэлд нь бусад тендерт оролцогчдод ил болгохыг хүлээн зөвшөөрч илгээнэ.

23.7. Тендерт оролцогч баримт бичиг, мэдээллийг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр нууцалж илгээх ба нууцалсан баримт бичиг, мэдээлэл нь тус үндэслэлд хамаарахыг тайлбарласан тайлбарыг нууцаар илгээх баримт бичигтэй хамт ирүүлнэ.

**24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

24.1. Тендерт оролцогч тендерийг ТӨХ-д заасан огноо, цагаас өмнө холбогдох журмын дагуу цахим системээр илгээнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацааг цахим системийн цагаар тооцно.

**25. Тендерт өөрчлөлт оруулах, тендерийг буцааж авах**

25.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцаан авах эрхтэй.

25.2. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш тендерт аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг солих, эсхүл буцааж авахыг зөвшөөрөхгүй ба холбогдох журмын дагуу захиалагч архивын нэгж үүсгэн хадгална.

25.3. Тендерт оролцогч илгээсэн тендерээсээ тендерийн нээлтээс хойш татгалзах хүсэлтэй бол энэ тухай захиалагчид албан бичгээр мэдэгдэнэ.

**26. Тендер нээх**

26.1. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр ТӨХ-д заасан огноо, цагт, заасан газарт зохион байгуулна.

26.2. ТШЗ-ны 26.1-д заасан газар зохион байгуулж буй тендерийн нээлтэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй. Нээлтэд биечлэн оролцсон этгээд тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурна.

26.3. Тендерийг нээх үед дараах мэдээлэл бүхий тэмдэглэлийг цахим системд байршуулна:

26.3.1. тендерт оролцогчийн нэр;

26.3.2. тендерийн үнэ;

26.3.3. санал болгосон бол үнийн хөнгөлөлт;

26.3.4. хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;

26.3.5. тендерийн баталгаа ирүүлсэн эсэх.

26.4. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол нээлтийн тэмдэглэлийг багц тус бүрээр үйлдэнэ.

26.5. Тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй. Энэ нь ТШЗ-ны 31, 32 дугаар зүйлүүдэд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх болон тендерийн үнийн арифметик алдааг залруулсан тохиолдолд хамаарахгүй.

## Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

**27. Нууцлах**

27.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх болон үнэлгээний дүгнэлттэй холбогдсон мэдээллийг тендер шалгаруулалтын үр дүн гарах хүртэлх хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй этгээд болон тендерт оролцогчдод задруулахгүй.

27.2. Тендерийг “хамгийн сайн” гэж үнэлсэн бол тендер илгээх маягтад дурдсанаар түүний нууцлаагүй хэсгийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгоно.

**28. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах**

28.1. Захиалагч тендерт оролцогчийн ирүүлсэн тендер, эсхүл цахим системээр илгээсэн мэдээлэл ойлгомжгүй, тодорхойгүй, зөрчилдөөнтэй гэж үзвэл зөвхөн уг асуудлыг тодруулах, тайлбар авах зорилгоор тендерт оролцогчийг энэ зүйлд заасны дагуу тодруулга ирүүлэхийг шаардах, эсхүл холбогдох бусад этгээдээс энэ тухай лавлагаа тодорхойлолт авах хүсэлт гаргаж болно.

28.2. ТШЗ-ны 28.1-д заасан тайлбар, тодруулгыг авахад талууд албан бичгээр харилцана.

28.3. Тендерт оролцогч захиалагчтай харилцах албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулж цахим системээр илгээж болно. Энэ тохиолдолд тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт хадгална.

28.4. ТШЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу хийсэн арифметик алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд тендерт оролцогчийг тендерийн агуулга, үнэд аливаа өөрчлөлт оруулахыг санал болгохгүй.

28.5. ТШЗ-ны 28.1-д зааснаар тайлбар тодруулга авах, эсхүл хуульд заасан үндэслэлээр тендерт оролцогчтой хэлэлцээ хийхээс бусад тохиолдолд захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хорооны гишүүд тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл тендерт оролцогч, түүний төлөөлөгчтэй ямар нэгэн уулзалт зохион байгуулахгүй, шууд болон шууд бусаар холбоо тогтоохгүй.

**29. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

29.1. Тендерийг ТШЗ-ны 13 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, тендерт оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар,

тодруулгад үндэслэн дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ:

29.1.1. тендерт оролцогчийн харьяалал ТШЗ-ны 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг зөрчөөгүй байх;

29.1.2. тендерт оролцогч, түүний туслан гүйцэтгэгч болон түншлэл ТШЗ-ны 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;

29.1.3. ТШЗ-ны 6 дугаар зүйлд зааснаар зөвхөн нэг тендер ирүүлсэн байх;

29.1.4. V бүлэг дэх маягтын дагуу ирүүлсэн баримт бичиг нь холбогдох шаардлага хангасан байх;

29.1.5. ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор хуулийн 14.1-д заасан нөхцөл тогтоогдоогүй байх;

29.1.6. ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерт оролцогч нь санхүүгийн, техникийн чадавхын болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байх;

29.1.7. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд үзүүлэхээр санал болгож буй үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж байх;

29.1.8. захиалагчийн тогтоосон эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлогдсон талуудын хүлээх эрх, үүргийг зөвшөөрсөн байх;

29.1.9. тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн байх.

29.2. Захиалагч тендерийн дараах зөрүүг жижиг хэмжээний зөрүү гэж үзэж болно:

29.2.1. ТШЗ-ны 29.1.7-д заасны дагуу хянан үзэхэд санал болгосон үйлчилгээ нь үйлчилгээний тодорхойлолтоос зөрүүтэй байгаа нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээргүй;

29.2.2. ТШЗ-ны 29.1.8-д зааснаар хянан үзэхэд тендерт санал болгосон гэрээний нөхцөл нь захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг дэх гэрээний нөхцөлөөс зөрүүтэй байгаа нь захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх хязгаарлалт оруулаагүй.

29.3. Хэрэв захиалагч ТШЗ-ны 29.2-т заасан жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрөх нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөхгүй бол тус тендерийг шаардлага хангасан гэж үзнэ.

29.4. Захиалагч IV бүлэгт жижиг хэмжээний зөрүүг залруулах аргачлалыг тусгаж болно.

29.5. Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрч, тендерийг шаардлага хангасан гэж үзсэн бол тендерийн үнийг ТШЗ-ны 29.4-т заасан аргачлалын дагуу хийсвэрээр нэмэгдүүлнэ.

29.6. Шаардлагад нийцсэн тендер гэж ТШЗ-ны 29 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерийн баримт бичгийн бүх нөхцөл, шаардлагыг буюу ТШЗ-ны 3-6, 11-24 дүгээр зүйлүүдэд заасан шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, тендер илгээх маягт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгад өөрчлөлт оруулаагүй тендерийг хэлнэ.

29.7. ТШЗ-ны 29.6-д зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.

29.8. Захиалагч нь ТШЗ-ны 29.7-д зааснаар тендерээс татгалзахдаа тендерт оролцогч нь ТШЗ-ны 16.1, 17.4, 17.5-д тендерт оролцогчоос шаардахгүй тухай тусгайлан заасан баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн гэж тендерээс татгалзахгүй.

**30. Тендерийг үнэлэх**

30.1. Захиалагч зөвхөн ТШЗ-ны 29.6-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн тендерийг хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

30.2. Хэрэв ТӨХ-д заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар үнэлнэ.

**31. Нэг валютад хөрвүүлэх**

31.1. Тендерийн үнэ болон төсөвт заасан үнийг ТШЗ-ны 20 дугаар зүйлд зааснаас өөр валютаар илэрхийлсэн тохиолдолд тендерийг үнэлэхэд тендер шалгаруулалт зарласан өдрийн Монгол банкны албан ханшийг үндэслэн тендерийн үнийг ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан валютад хөрвүүлнэ.

**32. Арифметик алдааг залруулах**

32.1. Шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерийн үнийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

32.1.1. нэг төрлийн үйлчилгээний нэр төрлийн мөр дэх нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэгж үнийг үндэслэн түүний мөр дэх нийт үнийг залруулна. Харин нэгж үнийн аравтын орны таслалыг илэрхий алдсан гэж үзвэл тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;

32.1.2. мөр дэх үнийн нийлбэр эсхүл ялгаварт алдаа байвал мөр дэх үнийг үндэслэн нийт үнийг залруулна;

32.1.3. тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж

тоон дүнг залруулна. Харин үгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаанаас шалтгаалсан бол ТШЗ-ны 32.1.1, 32.1.2-т нийцүүлэн тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.

32.2. ТШЗ-ны 32.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг тендерт оролцогчид хүргүүлнэ.

**33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

33.1.1. ТШЗ-ны 19 дүгээр зүйлд зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

33.1.2. ТШЗ-ны 32.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

33.1.3. ТШЗ-ны 19.5-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;

33.1.4. ТШЗ-ны 34.1.1-34.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 31 дүгээр зүйлд зааснаар нэг валютад хөрвүүлэх;

33.1.5. ТШЗ-ны 30.2-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

33.2. Тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсний дараах үнэ төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн бол хуулийн 30.1.3-ыг үндэслэн уг тендерээс татгалзана.

33.3. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

33.3.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 33.1-д заасны дагуу сонгох;

33.3.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35.2-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

33.3.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

33.4. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

33.5. ТШЗ-ны 33.4-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

**34. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх**

34.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг сонгохдоо хуулийн 28.7.3-т заасны дагуу тендерүүдийг эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.

34.2. Хуульд заасан үндэслэлээр тендерт оролцогчтой хэлэлцээ хийх тохиолдолд хэлэлцээний үр дүнд түүний тендерийн захиалагчийн тавьсан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үл хамаарах хэсэгт зөвхөн өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.

**35. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах**

35.1. Захиалагч хэд хэдэн багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадалж болно.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. Хэрэв тендерт оролцогчийг хэд хэдэн багцад гэрээ байгуулахад шаардлага хангахгүй гэж магадалсан бол түүний гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлагыг хангах нэг, эсхүл түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгоно.

35.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг дахин магадалж шаардлага хангахгүй гэж үзвэл уг тендерээс татгалзана. Энэ тохиолдолд удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж, оролцогчийн чадавхыг мөн адил зарчмаар магадална.

## Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

**36. Мэдэгдэл хүргүүлэх**

36.1. Захиалагч дараах мэдэгдлийн аль тохирохыг тендерт оролцогч тус бүрд бичгээр хүргүүлж, тухайн өдөрт багтаан цахим системд байршуулна:

36.1.1. “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох ;

36.1.2. ТШЗ-ны 36.1.1-т зааснаас бусад шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогчид шалгараагүй тухай мэдэгдэх;

36.1.3. ТШЗ-ны 29.7, 33.2-т заасан тендерээс татгалзах.

36.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол энэ тухай шийдвэр, мэдэгдэл болон "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийг холбогдох журмын дагуу ил болгох тухай ТШЗ-ны 36.1.2, 36.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.

36.3. Захиалагч бүх тендерээс татгалзсан бол хуулийн 30.4-т заасан дахин нээлттэй эсхүл хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах, эсхүл гэрээ шууд байгуулах тухай шийдвэрийг ТШЗ-ны 36.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.[3]

**37. Гэрээ байгуулах эрх олгох**

37.1. Захиалагч "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг ТШЗ-ны 36.1.1-д заасан мэдэгдлээр олгоно. Хэрэв "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана.

37.2. Дараах тохиолдолд хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн гэж үзэж тендерийн баталгааг улсын орлого болгоно:

37.2.1. гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд дурдсан гэрээний үнийг хүлээн зөвшөөрөөгүй;

37.2.2. ТШЗ-ны 38 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй (хэрэв гүйцэтгэлийн баталгаа шаардсан бол);

37.2.3. ТШЗ-ны 39 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

37.3. ТШЗ-ны 37.2-т заасан нөхцөл байдал үүсвэл удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзэж гэрээ байгуулах эрх олгоно.

**38. Гүйцэтгэлийн баталгаа**

38.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

38.2. Гүйцэтгэлийн баталгаа нь ТШЗ-ны 22.3-т заасан хэлбэрээр байж болох ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 22.4-т заасан шаардлагыг хангасан байна.

38.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

**39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

39.1. Захиалагч ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.

39.2. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

[3] Гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулах үед энэ заалт хамаарахгүй.

Захиалагчийн тогтоох энэ хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтсан байна.

39.3. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 39.2-т заасан хугацааны дотор гэрээг зохих ёсоор баталгаажуулж, гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн бол захиалагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

39.4. ТШЗ-ны 39.3-т заасан захиалагчийн үүрэг нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад эрх бүхий этгээд, эсхүл шүүхээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуульд заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл хэрэгжилтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

## Ё. БУСАД

**40. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**

40.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

**41. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт**

41.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.

41.2. Захиалагч ТШЗ-ны 41.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.

41.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.

41.4. Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-д зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.

41.5. ТШЗ-ны 41.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

**42. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх**

42.1. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системээр ил болгоно.

42.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

--o0o--

# II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

**Санамж**

Захиалагч авах зөвлөхөөс бусад үйлчилгээний онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн үйлчилгээ үзүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

-o0o-

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр**: Эрдэнэтийн ил уурхайд геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх ажил** |
| **ТШЗ 1.1** | Тендерийн урилгын дугаар: **ЭҮТӨҮГ/202202044** |
| **ТШЗ 1.3** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: **Багцгүй** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өөрийн хөрөнгөөр** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: 2,850,000,000.0 (хоёр тэрбум найман зуун тавин сая) төгрөг. |
| **Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА** | |
| **ТШЗ 8.2** | Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:<br>Хүлээн авагчийн нэр: **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**<br>Хаяг: **Орхон аймаг Баян-Өндөр сум, Найрамдал талбай Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Захиргааны 2-р байрны 348 тоот**<br>Утасны дугаар: **757-73598**<br>Цахим шуудангийн хаяг: khasherdene@erdenetmc.mn<br>Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчид бичгээр гаргаж болно. Ирүүлсэн тодруулгын хариуг цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д нийтлэх тул тендер нээх өдрийг хүртэл сайтад хандаж байхыг анхаарна уу. |
| **ТШЗ 9.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: **Үгүй** |
| **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ** | |
| **ТШЗ 12.1** | Тендерийн хэл Монгол хэл байна. Тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд гадаад хэл дээрх баримт бичгийг баталгаат орчуулгын хамт монгол хэл дээр ирүүлнэ. |
| **ТШЗ 15.1** | Хувилбарт санал ирүүлэхийг: **“Зөвшөөрөхгүй”** |
| **ТШЗ 16.1** | Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. /Тендерт оролцогчийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./ |

| | |
|---|---|
| **ТШЗ 16.1** | Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. |
| **ТШЗ 16.2.1** | Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.<br>Тус тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авч тендерт хавсарган ирүүлнэ. Хэрэв Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архив, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Шүүхийн тамгын газарт хариуцагчаар татагдаж байсан бол шат шатны шүүхийн шийдвэрийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.<br>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. |
| **ТШЗ 17.2** | Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: **“Шаардана”**<br>Борлуулалтын орлогын хэмжээ: Тендерт оролцогч нь 2020, 2021 оны аль нэг жилд төсөвт өртөгийн үнийн дүнгийн 50%- аас багагүй байна. |
| **ТШЗ 17.2.5** | Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: ***“Шаардана”***<br>1. **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн:** *Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.*<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:<br>*1.1. Байгууллагын тайлангийн түргэн хөрвөх хэсгийн үнийн дүн /цахим системээс шалгах тул ирүүлэх шаардлагагүй/*<br>*1.2. Байгууллагын харилцагч банкан дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа /дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна./*<br>*1.3. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт.*<br>2. Харилцагч банк тус бүрээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ. Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.<br>3. Тендерт оролцогч нь 2020, 2021 оны аль нэг жилд ашигтай ажилласан байна. |
| **ТШЗ 17.3** | Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа:<br>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *2020, 2021 онуудын аудитын дүгнэлт, хураангуй тайлангын хамт ирүүлнэ.* |
| **ТШЗ 17.6** | Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:<br>2020, 2021 онуудад ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх ба энэхүү туршлагад тооцуулах нийт гэрээний үнийн нийлбэр нь захиалагчийн батлагдсан төсөвт өртгөөс багагүй байна. |

| | |
|---|---|
| | Нотлох гэрээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлж ирүүлнэ. |
| **ТШЗ 17.6.1** | Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ***Шаардахгүй.*** |
| **ТШЗ 17.6.2** | Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: ***“Шаардана”.*** |

| № | Албан тушаал | Хүний тоо | Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага | Мэргэжил | Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багийн ахлагч | 1 | 25 | Төслийн менежмент, Уул уурхай/Геотехникийн инженер | Шаардана |
| 2 | Багийн дэд ахлагч | 1 | 15 | Уул уурхай менежмент/Геотехникийн инженер | Шаардана |
| 3 | Геотехникийн ерөнхий инженер | 1 | 10 | Геотехникийн инженер | Шаардана |
| 4 | Геотехникийн инженер (Өгөгдлийн сан бүрдүүлэлт, боловсруулалт) | 2 | 3 | Уул уурхай/ Геотехникийн инженер | Шаардана |
| 5 | Геотехникийн инженер (Модель, боловсруулалт, дизайнер) | 2 | 3 | Уул уурхай/ Геотехникийн инженер | Шаардана |
| 6 | Геотехникийн инженер (Мониторинг, хяналт шалгалт) | 2 | 3 | Уул уурхай/ Геотехникийн инженер | Шаардана |
| 7 | Структурийн геологич | 1 | 10 | Геологич | Шаардана |
| 8 | Гидрогеологич | 1 | 5 | Гидрогеологич | Шаардана |
| 9 | Уурхайн төлөвлөлтийн инженер | 1 | 5 | Уул уурхайн инженер/Менежмент | Шаардана |
| 10 | Маркшейдер | 1 | 5 | Уул уурхайн инженер/Маркшейдер | Шаардана |
| | | | | | |

- Дээрх ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.
- Дээрх ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын

мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Системээс 2011 оноос хойших мэдээллийг шалгах боломжтой бөгөөд түүнээс өмнөх мэдээллийг файлаар ирүүлнэ.

Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.

- “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ
- Хэрэв дээрх ажилтнууд гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.
- Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.
- Гадаадад мэргэжил эзэмшсэн дипломтой болон мэргэжлийн үнэмлэхтэй мэргэжилтнүүдийн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг орчуулгын хамт тендертээ хавсарган ирүүлнэ.
- Хүснэгтэд заасан ажилтнуудын 60-аас доошгүй хувь нь тухай байгууллагын үндсэн болон тухайн байгууллагын хамтран ажилладаг мэргэжлийн зөвлөх компани, судалгаа, шинжилгээний институтийн гэрээт зөвлөхөөр ажилладаг ажилтан байх

**ТШЗ 17.6.4**

**Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл:** *“Шаардлагатай”*

2020, 2021 онуудын хугацаанд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан, хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажил, үйлчилгээний жагсаалтыг дараах хүснэгтээр он тус бүрээр гаргаж ирүүлнэ.

| *№* | *Гэрээний нэр* | *Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс* | *Төсөвт өртөг* | *Дууссан, эсхүл дуусах хугацаа* |
|---|---|---|---|---|
| *1* | | | | |
| … | | | | |
| | *Дүн* | | | |

**ТШЗ 17.6.5**

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: ***“Шаардана”***

Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд:

1. Тендерт оролцогч нь 5 дугаар бүлэгт заасан “Тендерийн маягт, чадварын мэдээлэл, тендерийн баталгааны маягт”–ын МАЯГТ№1-8 дагуу мэдээллийг ирүүлнэ.
2. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн үйлчилгээг гүйцэтгэнэ тухай баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.
3. Захиалагчийн санаачлагаар шүүх, харилцагч банк, эрүүл мэнд нийгмийн даатгалын газар, оюуны өмч, улсын бүртгэлийн газар, татварын хэлтэс, өмнө үйлчлүүлсэн захиалагчаас болон бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн агуулга бүхий мэдэгдлийг тендерт оролцогч баталгаажуулан өөрийн тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.
4. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, төсвийн дүнтэй арифметик алдаанаас бусад тохиолдлоор зөрсөн, эсвэл үнийн хөнгөлөлт үзүүлж буй

| | |
|---|---|
| | тохиолдолд түүний үндэслэл, шалтгааныг дурдсан мэдэгдлийг шаардлагатай нотлох баримтын хамт баталгаажуулан ирүүлнэ. Үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт бүхий үнийн саналаас татгалзана.<br>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.<br>ТӨХ-д шаардсан материалуудын аль нэг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. |
| **ТШЗ 17.7.** | Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ***"Шаардахгүй"*** |
| **ТШЗ 17.8.** | Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэх бол тендерийн үнийн 10 хүртэл хувь байна. Дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:<br>1.Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байна. Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг, гэрээний үнийн дүн, хугацааг тодорхой тусгасан байна.<br>2.Туслан гүйцэтгэгч нь Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд уг мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана. |
| **ТШЗ 17.9.** | Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:<br>1.(а) түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна.<br>(б) Түншлэлийн гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үнийн дүн, хувийг тодорхой тусгасан байна.<br>(в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;<br>(г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;<br>(д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.<br>(е) түншлэлийн гишүүн бүр энэхүү ТӨХ-д заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ.<br>Хамгийн доод шалгуур:<br>Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. ТШЗ-ны 17.2-т борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6-д ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг тус тус заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.<br>Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.<br>*Анхааруулга: Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 3.3.1-д "Тендерт оролцогч нь түншлэлээр оролцох бол талууд цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх;" гэж заасны дагуу цахим системээр дамжуулан гэрээ байгуулаагүй тохиолдолд уг журмын 3.11-д "Тендерт оролцогч тендер илгээхдээ журмын 3.3.1-д заасаар түншлэлийн бусад гишүүдтэй гэрээ байгуулаагүй бол хуулийн 5.1.6.б-д заасан тендерт оролцогч гэж үзэхгүй" гэж заасны дагуу түншлэлээр тендерт оролцсон гэж үзэхгүй болохыг анхаарна уу.* |

| | |
|---|---|
| **ТШЗ 19.6.** | **Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад:** Тохируулахгүй тогтмол байна. |
| **ТШЗ 22.1** | Тендерийн баталгаа: ***“Шаардана”***<br>Тендерийн баталгааны үнийн дүн: **Төсөвт өртөгийн 0,5 хувь байна**<br>Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем цахим тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн цахим тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.<br>Хүчинтэй байх хугацаа: Тендер нээснээс хойш 58 хоног түүнээс дээш байна. |
| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
| **ТШЗ 23.1.** | Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх бол итгэмжлэл гаргаж ирүүлнэ.<br>Хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулсан тохиолдолд итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй. |
| **ТШЗ 23.5.3** | ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:<br>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ. |
| **ТШЗ 24.1.** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: 2022 оны 11 сарын 04-ний өдөр<br>Цаг: 09 цаг 00 минут<br>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй. |
| **ТШЗ 26.1.** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: 2022 оны 11 сарын 04-ний өдөр<br>Цаг: 09 цаг 15 минут<br>Тендер нээх газрын хаяг: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Баян-өндөр сум, Найрамдал талбай-1, Ерөнхий захиргааны 2-р байр 3-р давхрын 348 тоот |
| **Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ** | |
| **ТШЗ 30.2** | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ***“Ашиглахгүй”*** |
| **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ** | |
| **ТШЗ 38.1** | Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: ***“Тийм”***<br>ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. |
| **Ё. БУСАД** | |
| **ТШЗ 41.1** | Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй |

## III БҮЛЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

| ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | |
|---|---|
| **1.1 Захиалагч байгууллагын нэр, хаяг** | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай |
| **1.2 Төсөл хэрэгжих талбай** | Орхон аймаг, Баян-Өндөр сум |
| **1.3 Ажлын нэр** | Эрдэнэтийн ил уурхайд геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх |
| **1.4 Ажил гүйцэтгэх үндэслэл** | Эрдэнэтийн ил уурхайн ахилт эрчимтэй явагдаж, ил уурхайн хүрээ тэлж, гүнзгийрэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан уурхайн хажуугийн тогтворжилт, ордын геотехникийн нөхцөл хүндрэх эрсдэл байгаа тул уурхайн геотехникийн эрсдэлийг урьдчилан таамаглаж, нөхцөл байдлыг бодитой, хэмжигдэхүйц байдлаар үнэлэх, мөн ордын хагарлын бүсүүдэд явагдаж байгаа уурхайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй газрын гүний хяналтгүй шилжилт хөдөлгөөний эрсдэлийг бууруулж хянахын тулд илүү нарийвчилсан, ахисан түвшний технологи бүхий шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлэх замаар геотехникийн цогц хөтөлбөрийг нэвтрүүлэх шаардлагатай байна. Үүнд:<br>• Ил уурхайн бүх талын хажуугийн тогтвортой байдлыг хангахын тулд уурхайн хажуугийн зохистой өнцгийг төлөвлөх хамгийн сайн туршлага, талбайн хяналт, түүний дотор геотехникийн хамгийн тохиромжтой техник хэрэгсэл, программ хангамж, технологийг ашиглах,<br>• Ил уурхайн геотехникийн инженерчлэлийн нэгжийн чиг үүрэг, тэдгээрийн бусад цех, хэлтэстэй холбогдож ажиллах, тухайлбал геологи, уурхайн төлөвлөлт, уурхайн олборлолт, гидрогеологи, уурхайн хаалт, тогтвортой байдал, эрсдэлийн удирдлага, байгаль орчин зэрэг техникийн салбаруудтай харилцах ажлын горимын уялдаа холбоог дахин хянаж, сайжруулах,<br>• Геотехникийн инженерийн багийг бүрдүүлэх, инженер техникийн ажилчдын практик туршлага, ур чадварыг сайжруулах олон улсын жишигт нийцсэн сургалт, дадлагын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,<br>• Эрдэнэтийн ил уурхайн геотехникийн хяналтыг аюулгүй, практик, зардал багатай хийх шийдлийг эрэлхийлсэн зохистой аргачлалыг санал болгох. |
| **1.5 Судалгааны ажлын зорилго** | • Уурхайн техникийн үйлчилгээний чиг үүргийн салшгүй хэсэг болох ил уурхайн талбайн геотехникийн инженерийн нэгжийн чиг үүргийг зохих ёсоор хөгжүүлэх;<br>• Уурхайн стратегийн төлөвлөлттэй уялдаа холбоог бий болгож, одоогийн ил уурхайн үйл ажиллагаа, өргөтгөлийн төслүүдэд үр дүнтэй техникийн дэмжлэг, зааварчилгаа өгөх;<br>• Уурхайн үйлдвэрлэлийн зорилтод аюулгүй, үр ашигтай хүрэхийн тулд геотехникийн инженерийн дэмжлэг үзүүлэх, талбайн геотехникийн инженерүүдийн ур чадвар, чадавхыг хөгжүүлэх; |

| | |
|---|---|
| | • Төлөвлөсөн хугацаанд уурхайн геотехникийн зөвлөгөөг илүү үр ашигтайгаар хүргэх шинэчилсэн буюу сайжруулсан геотехникийн туршлага, хэрэгслийг бий болгох;<br>• Уурхайн үндсэн үйл ажиллагаа, уурхайд хэрэгжиж буй төслүүдийн геотехникийн эрсдэлийг бууруулахын тулд уурхайн зураг төсөл болон уурхайн төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай байгаа талаар уурхайн удирдлагад цаг тухайд нь, зөв зохистой зөвлөгөө өгөх зорилгоор үр дүнтэй, оновчтой үйл явц, үүрэг, хариуцлагын функцийг боловсруулах;<br>• Уурхайн геотехникийн эрсдэлийг удирдахад шаардагдах стандарт, протокол, түүний дотор геотехникийн эрсдэлийн үнэлгээ хийх протоколыг боловсруулах;<br>• Уурхайн хаалтын төлөвлөгөөний геотехникийн бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах;<br>• Уурхайн төлөвлөгөөний ашиглалтын хугацаанд одоогийн болон ирээдүйн уурхайн хажуугийн зохистой зураг төслийг гаргах үйл явцыг бий болгож, ижил төстэй олон улсад шалгагдсан туршлагыг нэвтрүүлэх;<br>• Геотехникийн инженерчлэлийн практикийн бүх хүрээг хамарсан геотехникийн инженер, техникийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх,<br>• Богино, дунд, урт хугацаанд шаардагдах геотехникийн инженерийн технологийн төлөвлөлтийн зургийг боловсруулах;<br>• Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн геомеханикийн үзэгдлийн судалгааг орон нутгийн их, дээд сургууль, хүрээлэнгүүдтэй хамтран хэрэгжүүлэх судалгаа, хөгжлийн төслийг эхлүүлэх, шинэ мэдлэгийг хөгжүүлэх, ирээдүйн геотехникийн инженерүүдийг бэлтгэх зэрэг тасралтгүй сургалтын модулиудыг хөгжүүлэх;<br>• Газар нутгийн онцлогт тохирсон уурхайн хажуугийн геотехникийн хяналтын менежментийн төлөвлөгөө (SMP) болон эрсдэл бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө (TARP) боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх;<br>• Уурхайн талбайн геотехникийн аюулын талаарх мэдээллийг мэдээлэх үйл явцыг боловсруулах;<br>• Уурхайн ашиглалтын хугацааны төлөвлөлтөд геотехникийн чиглэлээр оруулах хамаарах хэсгийн үйл явцыг боловсруулах, нөөц буюу хувилбарт дүн шинжилгээ хийх;<br>• Ил уурхайн үйл ажиллагааг уурхайн ашиглалтын хугацаанд аюулгүй, үр дүнтэй байлгах үүднээс геотехникийн гүйцэтгэлийн хяналт, уурхайн дизайныг дахин үнэлэх систем, үйл явцыг боловсруулж, нэвтрүүлэх. |
| **1.6 Ажил гүйцэтгэх үе шат, цар хүрээ** | Эрдэнэтийн ил уурхайд геотехникийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх гүйцэтгэгч нь геотехникийн чиг үүрэг бүхий функцийн ажлуудыг шинээр бий болгох ба олон улсын шилдэг туршлагын жишигт нийцсэн шинэ, боловсронгуй геотехникийн процесс, дүрэм журам, техник технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгслийн системийн ашиглалтыг нэвтрүүлэх замаар Эрдэнэтийн ил уурхайг илүү сайжруулсан уурхайн загвар дизайн, ашиглалтын аюулгүй байдал, илүү үр ашиг, эрсдэлийн удирдлага бүхий ажлын горимын системээр хангах ажлыг зохион байгуулан гүйцэтгэнэ.<br><br>Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ уурхайн хэлтэс, нэгжийн зохион байгуулалт, чиг үүргийн бүтцэд өөрчлөлт оруулах, ажлын горимын шинэ үйл явц, дүрэм журам, шинэ технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, программ хангамжийг нэвтрүүлэх, одоогийн болон ирээдүйн геотехникийн |

| | |
|---|---|
| | мэргэжилтнүүдийг танхимын болон практик сургалтын хөтөлбөрөөр сургах замаар хэрэгжүүлнэ. Үүний тулд Геотехникийн цогц хөтөлбөр нь дараах ажлын багцуудын нэгтгэлээс бүрдэх ба үе шат дараалдлыг нарийн төлөвлөлттэй зохион байгуулснаар нэгдсэн үр дүнд хүрнэ.<br>АБ 1 Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээ буюу Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн геотехникийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлж үнэлэх шинжилгээ<br>АБ 2 Геотехникийн чиглэлээр мөрдөх шаардлагатай Монгол улсын хууль эрх зүй, дүрэм журам, түүнийг хэрэгжүүлж буй Эрдэнэт үйлдвэрийн байгууллагын бүтэц удирдлагын тогтолцооны уялдаа холбоог хянан үзэх, үнэлэх<br>АБ3 Геотехникийн инженерчлэлийн шинээр нэвтрүүлж дагаж мөрдөх шаардлагатай байгууллагын дотоод дүрэм журам, стандартыг боловсруулах<br>АБ 4 Геологи геотехникийн мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, удирдах систем боловсруулах<br>АБ 5 Геологийн модельд геотехникийн шинж чанарын загварыг оруулах, хөгжүүлэх, удирдах, хянах<br>АБ 6 Геологийн структурын загварчлалд геотехникийн шинж чанарын загварыг оруулах, хөгжүүлэх, удирдах, хянах<br>АБ 7 Чулуулгийн физик-механик шинж чанарыг тодорхойлох, модель загвар үүсгэх<br>АБ 8 Чулуулгийн массын загварыг хөгжүүлэх, загварчлах: Геотехникийн домэйн үүсгэх<br>АБ 9 Геотехникийн модель загварыг үүсгэж хөгжүүлэх, удирдах, хянах<br>АБ 10 Гидрогеологийн модель загварыг үүсгэж хөгжүүлэх, удирдах, хянах<br>АБ 11 Ил уурхайн геотехникийн зураг төсөл боловсруулах, ажлын процессыг хөгжүүлж хэрэгжүүлэх, уурхайн хажуугийн өнцгийг төлөвлөх, арга зүйг боловсруулах<br>АБ 12 Ил уурхайн ханаы налуугийн тоон загварчлалыг боловсруулах<br>АБ 13 Уурхайн ус шавхалтын стратеги боловсруулах- гүний усны менежмент<br>АБ 14 Чулуулгийн массын шинж чанарын тодорхойлолт<br>АБ 15 Өрөмдлөг тэсэлгээний загварчлалыг геотехникийн загварчлалтай уялдуулах<br>АБ 15 Геотехникийн болон уурхайн төлөвлөлт, уулын ажлын олборлолтын дарааллыг нэгтгэх, уялдуулах<br>АБ 16 Геотехникийн болон уурхайн төлөвлөлт, уулын ажлын олборлолтын дарааллыг нэгтгэх, уялдуулах<br>АБ 17 Орд газрын ан цавшил, уурхайн үндсэн хагарлын бүсүүдийн хяналт, мониторинг<br>АБ 18 Уурхайн геотехникийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлийг бууруулах, удирдах<br>АБ 19 Уурхайн хаалтын геотехник<br>АБ 20 Газрын гүний хөдөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөө<br>АБ 21 Эрдэнэт үйлдвэрт ашиглах геотехникийн техник технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, программ хангамжийг тодорхойлох, системийг нэвтрүүлэх |

| | |
|---|---|
| | АБ 22 Геотехникийн тайлагналтын систем<br>АБ 23 Геотехникийн сургалтууд<br>АБ 24 Геотехникийн инженеринг нэгжийн байгууллагын бүтэц чиг үүрэг / хэлтэс нэгжийн зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжүүлэлт<br>АБ 25 Геотехникийн технологийн инноваци, судалгаа хөгжлийн төслүүдийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт<br>Геотехникийн инженер техникийн ажилтнуудыг олон улсын туршлага судлуулах, сургах, ажлын байран дахь интерншип хөтөлбөр хэрэгжүүлэх<br>АБ 26 Геотехникийн инженер техникийн ажилтнуудыг олон улсын туршлага судлуулах, сургах, ажлын байран дахь интерншип програм хэрэгжүүлэх<br>АБ 27 Ажлын онцгой нөхцөл |
| **ТАВИГДАХ ШААРДЛАГА** | |
| **2.1 Туршлага ур чадвар** | - Геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч нь уул уурхай, геологи хайгуулын салбарт үйл ажиллагаа явуулдаг, хамгийн багадаа 10 жилийн турш олон улсын хэмжээнд уул уурхайн геотехникийн судалгаа, зөвлөгөө өгч ажилласан туршлагатай, олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ASTM ба ISRM стандартын норм, дүрмийн дагуу дээж бэлтгэл, боловсруулалт, шинжилгээний ажлыг гүйцэтгэж захиалагч талд тайлагнах чадвартай, олон улсад итгэмжлэгдсэн геотехникийн зөвлөх инженерүүд экспертүүд болон Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг, олон улсын түвшинд хэрэгждэг бусад уурхайн төслүүдэд, олон улсын стандартын шаардлагад нийцсэн системд 3-10 жилийн хугацаанд ажилласан туршлагатай геотехникийн болон бусад холбогдох чиглэлээр ажилласан мэдлэг, туршлагатай Монгол инженерийн техникийн багийн гишүүдийг багтаасан мэргэжлийн боловсон хүчнээр гүйцэтгэлийн багт бүрдүүлсэн бол давуу тал болно.<br>- Гүйцэтгэгч нь дараах геотехникийн зөвлөх болон гүйцэтгэх ажлуудын чиглэлээр олон улсын уул уурхайн зах зээлд мэргэшсэн ур чадвартай гүйцэтгэгч байна. Үүнд:<br>• Геотехникийн зөвлөгөө<br>• Геотехникийн эрсдэлийн менежмент<br>• Уурхайн хаалтын геотехникийн төлөвлөлт<br>• Уурхайн олборлолтын үеийн үйл ажиллагаанд геотехникийн дэмжлэг үзүүлэх<br>Геотехникийн инженерчлэлийн чиглэлээр:<br>• Уурхайн хөрсний овоолго түүний геотехникийн инженерчлэл, тогтворжилт<br>• Дэд бүтцийн газрын инженерчлэл<br>• Геотехникийн ахисан түвшний мэдлэгийн ахиц дэвшил болон R&D инноваци хөгжүүлэгч, хэрэгжүүлэгч<br>- Геотехникийн зөвлөх болон геотехникийн гүйцэтгэгчийн ажлын ур чадвар туршлагаар олон улсын уул уурхайн салбарт хамгийн багадаа арван уурхайн төслүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө, систем нэвтрүүлэх, гүйцэтгэгчээр дараах чиглэлүүдээр ажилласан байх: Үүнд:<br>• Ил уурхайн геотехникийн талбайн дэмжлэг<br>• Ил уурхайн геотехникийн хөндлөнгийн хяналт, шалгалт |

| | |
|---|---|
| | • Ил уурхайн геотехникийн ТЭЗҮ<br>• Далангийн аюулгүй байдлын хяналт, геотехникийн иж бүрэн үзлэг<br>• Бие даасан техникийн үзлэг (ажлын доголын налуугийн эвдрэл, нөлөөллийн шалтгаанууд)<br>• (IFC) буюу уурхай орчмын дэд бүтцийн байгууламжийн геотехникийн загвар, хяналт<br>• Гадаргын ус зайлуулах суваг, ил уурхайн геотехникийн асуудлыг дахин төлөвлөх<br>• Уул уурхайн геотехникийн ажлыг сэргээхэд техникийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ<br>• Ил уурхайн өргөтгөлийн геотехникийн техникийн хяналт<br>• Ил уурхайн эцсийн хананы налуу, босоо хана өндөр, налуугийн загварчлал, хяналт |
| **2.2 Техникийн шаардлага** | Гүйцэтгэгч нь дараах техникийн шаардлагуудыг заавал хангасан байх ба тухайн ажлын онцлог эсвэл захиалагч нь шаардлагатай тохиолдолд харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.<br>- Ажил гүйцэтгэхтэй холбоотой ХАБЭА-ын дотоод дүрэм, журам боловсруулан, баталгаажуулсан байх.<br>- Гүйцэтгэх ажлын шаардлагаар авагдсан төрөл бүрийн дээжийг тухайлбал өрмийн чөмгөн дээжүүдийн чулуулгийн физик механик шинж чанарыг тодорхойлох чиглэлээр зөвлөмж гаргах, шинжилгээний үр дүнг боловсруулах мэргэжлийн программ хангамж системийг ашигладаг байх.<br>- Стандартын шаардлага хангасан, олон улсад итгэмжлэгдсэн геотехникийн зөвлөх инженерийг багтаасан боловсон хүчнээр хангагдсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх<br>- Геотехникийн болон судалгаа шинжилгээний арга аргачлал, олон улсын стандартыг баримтлан ажилладаг байх.<br>- Чанарын хяналт, чанарын баталгааны стандарт баримтлан ажилладаг бие даасан, ажлын процедур, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажилладаг системтэй байх.<br>- Чулуулгийн дээж, өгөгдөл цуглуулах, өгөгдлийн сан үүсгэх, боловсруулалтын ажил гүйцэтгэх чадвартай бие даасан зөвлөхүүдтэй хамтран ажилладаг байх.<br>- Олон улсын уул уурхай үйлдвэрлэлийн салбарт геотехникийн болон бусад холбогдох чиглэлээр мэргэшсэн, нэр хүнд бүхий институт, байгууллага, бие даасан зөвлөхүүдтэй хамтран ажилладаг, тэдгээрийг тус геотехникийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд татан оролцуулах, хамтран ажиллах чадавхитай байх. |
| **2.3 Арга аргачлал** | Геотехникийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх явц нь тус хөтөлбөрийг ил уурхайд хэрэгжүүлэхэд ажлын ялгаатай процесс бүрд шийдвэрлэх шаардлагатай 26 төрлийн үе шат бүхий дараах ажлын багцуудаас (АБ) бүрдэнэ. Эдгээр ажлын багцууд нь Ажлын багц №1 буюу (АБ1)-ийг хийж гүйцэтгэснээр нарийвчлан тодорхойлогдох ба Ажлын багцуудыг (АБ) хийгдэх ажлуудын гүйцэтгэлийн явцаас хамаарч Цогц хөтөлбөр хэрэгжих нийт хугацааны үе шат тус бүрд ажлын тайлан хүргүүлэх түвшинг дараах 3 түвшинд тодорхойлогдоно.<br>**Ажлын Багц №1** |

| | |
|---|---|
| | **Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээ: Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн геотехникийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлж үнэлэх шинжилгээ**<br>• Уурхайн үйл ажиллагааны геотехникийн функцийн өмнө хийгдсэн болон одоогийн чадавх, зохион байгуулалтыг үнэлэх, хянах;<br>• Одоогийн ашиглаж байгаа техник технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, технологиудыг шалгах, үнэлэх<br>• Уурхайн үйл ажиллагаан дахь циклийн үйл явц бүрийн одоогийн горимуудыг хянаж, шилдэг туршлагад нийцүүлэн зураглах;<br>• Уурхайн өгөгдлийн сан болон одоо байгаа мэдээллүүдийн өгөгдлийн тайлан, формат, бүрэн бүтэн байдал, тууштай үр ашигтай эсэх, хэрэглэгдэхүүний байдлыг шалгах;<br>• Ажлын урсгалын шинэчилсэн диаграммд алхам бүрд шаардагдах баримт бичгийн жагсаалт гаргах;<br>• Геотехникийн чиглэлээр ажиллаж байгаа болон холбогдон ажиллах инженер техникийн ажилтнуудын өнөөгийн ур чадварыг тодорхойлж ажлын шаардагдах ур чадварын матрицыг боловсруулах;<br>• Геотехникийн процессын ажлын өнөөгийн схемийг эмхэтгэх;<br>• Өнөөгийн уурхайн үйл ажиллагааны геотехникийн хамаарал бүхий үйл явцыг хянаж, орхигдуулж байгаа ажлуудын дүн шинжилгээ хийж, нэмэлт шаардлагатай байгаа ажлуудын зураглалыг хийх;<br>• Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалахын тулд мэдээллийн сан, тайлангуудын эмхэтгэлийг (хянах) тогтоосон болон шинээр нэвтрүүлэх зөв зохистой форматаар боловсруулах;<br>• Геотехникийн удирдах болон инженер техникийн ажилтнуудын сургалт, ажлын байран дахь дасгалжуулалтын хэрэгцээг тодорхойлж, хянах, шинэ журмыг хэрэгжүүлэх;<br>• Шинэ системд үйл явцыг тусгахын тулд геотехникийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг хянах;<br>• Геотехникийн өрөмдлөгийн хөтөлбөрүүдийг хянах, төлөвлөх, ажлын горимыг удирдах;<br>• Уурхайн зураг төсөл, оновчлолын өмнөх тоон загварчлалын ажлыг эргэн харах;<br>• Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээг харьцуулж, ажлын цар хүрээ, багцалсан ажлуудыг хэрэгжүүлэх үе шатуудыг тохируулах, баталгаажуулах;<br>• Ажлын багцын бүх техникийн даалгаврын тоймыг боловсруулж хянах, АБ1-ийн үр дүнгээр тодорхойлогдсон зөвлөмжийн дагуу Үе шатууд болон АБ-уудыг тохируулна: Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээний үр дүнгийн дагуу Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаг хугацаа, төсөвт өртгийг үе шат болон ажлын багц тус бүрд нарийвчлан тодорхойлох;<br>• Геотехникийн цогц хөтөлбөрийн ажлын цар хүрээг эцсийн байдлаар нарийвчлан тодорхойлж хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн удирдлагад танилцуулж ажлын даалгаврыг батлуулах. |

| | |
|---|---|
| | **Ажлын Багц №2**<br>**Геотехникийн чиглэлээр мөрдөх шаардлагатай Монгол Улсын хууль эрх зүй, дүрэм журам, түүнийг хэрэгжүүлж буй Эрдэнэт үйлдвэрийн байгууллагын бүтэц удирдлагын тогтолцооны уялдаа холбоог хянах, үнэлэх**<br>• Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм, Тогтвортой хөгжил, Байгаль орчны тухай хууль болон ил уурхайн зураг төсөл боловсруулах, ашиглах, уурхай хаахад анхаарах шаардлагатай геотехникийн хүчин зүйлүүдтэй холбоотой холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмыг хянаж үзэн үйл ажиллагааны горимд уялдуулах.<br>• Хууль тогтоомж, уурхайн бодлого, дүрэм журмын дагуу аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны менежментийн шилдэг туршлагыг сурталчлах, дэмжих, хэрэгжүүлэх чиглэлээр уурхайн талбайд хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах;<br>**Ажлын Багц №3**<br>**Геотехникийн инженерчлэлийн шинээр нэвтрүүлж дагаж мөрдөх шаардлагатай байгууллагын дотоод дүрэм журам, стандартыг боловсруулах**<br>• Геотехникийн мэдээллийг цуглуулах, удирдах журмыг боловсруулах, Үүнд: чөмгөн дээжийн геологи, геотехник, структурын бичиглэл хийх, ориентэйшн зураглал хийх арга техникүүд;<br>• Уурхайн ханаы налуугийн гүйцэтгэлийн хяналт хийх ажлын процедурын журам боловсруулах;<br>• Талбайн хяналт шалгалт хийх журмыг боловсруулах;<br>• Уурхайн ханаы тогтворжилтын тогтвортой байдлын загварчлал, дүн шинжилгээ хийх, нэгтгэх журмыг боловсруулах;<br>• Уурхайн ус шавхалт, усгүйжүүлэх үйл ажиллагааны журам боловсруулах;<br>• Геотехникийн талбайн үзлэг, хяналт шалгалтыг тайлагнах журмыг боловсруулах;<br>**Ажлын Багц №4**<br>**Геологи геотехникийн мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, удирдах системийн боловсруулалт**<br>• Бодит цагийн хяналт хийх мэдээлэл цуглуулах систем;<br>• Мэдээлэл боловсруулах, хадгалах систем;<br>• Өгөгдлийн харилцаа холбоо, дамжуулах систем, мэдээллийн тайлан;<br>**Ажлын Багц №5**<br>**Геологийн модельд геотехникийн шинж чанарын загварыг оруулах, хөгжүүлэх, удирдах, хянах**<br>**Ажлын Багц №6**<br>**Структурын загварчлалд геотехникийн шинж чанарын загварыг оруулах, хөгжүүлэх, удирдах, хянах**<br>• Ил уурхайн ханын зураглалын тохирсон аргачлал нэвтрүүлэх<br>• RQD загвар боловсруулах |

| | |
|---|---|
| | **Ажлын Багц №7**<br>**Чулуулгийн физик-механик шинж чанарыг тодорхойлох**<br>• Модельд шаардлагатай чулуулгийн физик-механик шинж чанаруудыг лабораторийн шинжилгээнүүдийн дээжийн интервалыг агуулагч чулуулгийн 3 хэмжээст загварчлал дээр үндэслэн тодорхойлох.<br>• RMR, IRMR, MRMR, Hoek-Brown GSI зэрэг чулуулгийн массын үнэлгээ хийх<br>**Ажлын Багц №8**<br>**Чулуулгийн массын загварыг хөгжүүлэх, загварчлах: Геотехникийн домэйн үүсгэх**<br>**Ажлын Багц №9**<br>**Геотехникийн модель загварыг үүсгэж хөгжүүлэх, удирдах, хянах**<br>• Геотехникийн өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн боловсруулалт, тайлал хийх замаар уурхайн геологи, структур, чулуулгийн физик-механик шинж чанар, гидрогеологийн тогтцыг хамарсан уурхайн хажуугийн тогтворжилтын хяналтад тохиромжтой геотехникийн загварыг боловсруулах;<br>• Эдгээр моделиудыг үүсгэхдээ ил уурхайн ашиглалтын эцсийн хүрээнээс гадагш 600 м ахилттай талбайг хамруулах.<br>**Ажлын Багц №10**<br>**Гидрогеологийн модель загварыг үүсгэж хөгжүүлэх, удирдах, хянах**<br>• Гидрогеологийн гол үзүүлэлтүүдийг гарган авахад уурхайн талбайн усгүйжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө багтана;<br>• Газрын гүний усны урсгал ба даралтыг тодорхойлох<br>• Газрын гүний усны загварчлал ба шинжилгээ<br>• Уурхайн хананы тогтвортой байдалд гүний усны урсгал ба даралтын нөлөөллийг үнэлэх<br>**Ажлын Багц №11**<br>**Ил уурхайн геотехникийн зураг төсөл боловсруулах, ажлын процессыг хөгжүүлж хэрэгжүүлэх; уурхайн хажуугийн өнцгийг төлөвлөх, арга зүйг боловсруулах**<br>• Уурхайн аюулгүй байдал, оновчтой үйл ажиллагааг дэмжих геотехникийн загварчлалын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах<br>• Уурхайн налуугийн ерөнхий өнцөг, ажлын догол болон уурхайн дотоод доголууд, зам хоорондын налуу, мөргөцгийн геометр гэх мэт хананы налуугийн загварын параметрүүдийг тодорхойлохын тулд ажлын доголуудын загварчлалын шинжилгээний протоколуудыг нэвтрүүлэх<br>• Эдийн засгийн шалгуур үзүүлэлтийг ашиглан ажлын болон уурхайн хананы налуу хоорондын төлөвлөлтийн шинжилгээг хийж, налуу хоорондын өнцгийг сонгох;<br>• Тасралтгүй байдлын зохих дэг журамд нийцэх кинематик (стереограф ба блок шинжилгээний аргууд) шинжилгээний процессыг боловсруулах;<br>• Уурхайн ашиглалтын хугацааны батлагдсан зураг төслийг геотехникийн хувьд үнэлэх; |

| | |
|---|---|
| | • Геотехникийн хувьд үнэлэгдсэн уурхайн хананы шинэ загварыг хөгжүүлж хэрэгжүүлэх<br>**Ажлын Багц №12**<br>**Ил уурхайн хажуугийн тоон загварчлалыг боловсруулах**<br>• Ил уурхайн хажуугийн тогтвортой байдлыг үнэлэхэд тохиромжтой тоон загварчлалын аргыг тодорхойлох;<br>• Уурхайн талбайд нэвтрүүлэх тоон загварчлалын багц/программ хангамжийг тодорхойлох;<br>• Тус тоон загваруудыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллах ажлын удирдамжийг боловсруулах:<br>• Уул уурхайн өнөөгийн болон ирээдүйн үе шатыг үнэлж дүгнэсэн тоон загваруудыг бий болгох;<br>• Ил уурхайн хажуугийн тогтворжилтын тоон шинжилгээ хийх ажилчдыг сургах;<br>• Инженер техникийн ажилчдыг чулуулгийн нурлын шинжилгээний аргачлалд сургах;<br>**Ажлын Багц №13**<br>**Уурхайн ус шавхалтын стратеги боловсруулах- гүний усны менежмент**<br>• Налуугийн тогтвортой байдалд гүний усны нөлөөллийг тодорхойлох; Уурхайн загварчлалд үр нөлөөг тусгах;<br>• Чулуулгийн массын нүх сүвшилийн даралтыг тодорхойлох;<br>• Усны нэвчилт, урсцаар чулуулгийн сул зурвасын гадаргуугийн элэгдэлд үзүүлэх нөлөө;<br>• Гадаргуугийн ус зайлуулах, уурхайн ус зайлуулах, усгүйжүүлэх техникийн шаардлага, арга аргачлал;<br>**Ажлын Багц №14**<br>**Чулуулгийн массын шинж чанарын тодорхойлолт**<br><br>• Ордын геологийн талбайн хүрээ домайн, уурхайн хилийн хүрээ хязгаарын доторх чулуугийн массын шинж чанарын тодорхойлолт, өмнөх хийгдсэн судалгааны ажлуудыг хянах хэрэглээг тодорхойлох;<br>**Ажлын Багц №15**<br>**Өрөмдлөг тэсэлгээний загварчлалыг геотехникийн загварчлалтай уялдуулах**<br>• Уурхайн ханын тогтворжилт нь тэсэлгээтэй шууд холбоотой тул өрөмдлөг, тэсэлгээний оновчлолын сайжруулсан загварыг боловсруулж геотехникийн хяналтыг сайжруулах;<br>• Чулуулгийн масс болон уурхайн хананы налуугийн эвдрэлийг багасгах оновчлогдсон өрөмдлөг тэсэлгээний үйл ажиллагааг нэвтрүүлэх<br>• Үүндээ тохирсон тэсэлгээний гал өгөх системийг сонгох болон тэсэлгээ эхлэлийн дараалалын схемийг оновчлох;<br>• Уурхайн хананы тогтворгүй байдлыг багасгахын тулд тэсэлгээний өрөмдлөгийн цооногийн байрлал, цооногийн түгжээ, цооногийн налуу, уртыг хянах; |

| | |
|---|---|
| | • Уурхайн ханаы ойролцоох цооногийн тэсрэх энергийн түвшинг нарийвчилж, мөргөцөг болон хүрээ доголын налуугийн тэсэлгээний эвдрэлийг багасгах, оновчлох;<br>**Ажлын Багц №16**<br>**Геотехникийн болон уурхайн төлөвлөлт, уулын ажлын олборлолтын дарааллыг нэгтгэх, уялдуулах**<br>• Геотехникийн инженерчлэлийн бодит байдлын үнэлгээнд үндэслэсэн аргуудыг ашиглан уурхайн төлөвлөлт, зураг төслийн системчилсэн хандлагыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, уялдуулах;<br>• Богино дунд болон урт хугацааны төлөвлөлтийн үе шатуудад уурхайн төлөвлөлт, уурхайн загварчлалын ажлын үйл явцын хүрээнд геотехникийн инженерийн үнэлгээний аргыг боловсруулж, нэвтрүүлэх;<br>**Ажлын Багц №17**<br>**Орд газрын ан цавшил, уурхайн үндсэн хагарлын бүсүүдийн хяналт, мониторинг**<br>• Уурхайн хэмжээнд геотехникийн хяналтын системийг суурилуулах ажлыг төлөвлөх, удирдах;<br>• Уурхайн ханаы хөдөлгөөнийг илрүүлэхийн тулд ханаы налууг хянах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;<br>• Уурхайн хүрээн дэх газрын гүний хөдөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөө, мониторингийн стратеги боловсруулах;<br>• Хэмжилтийн өгөгдлийн сангийн бүртгэл, мэдээллийн тайлал, ажлын үр дүнгийн тайлагнах үйл явцын хяналт хийхэд тохиромжтой аргуудыг ашиглах;<br>• Чулуулгийн нурал, гулсалт шилжилтийн үйл явцыг илрүүлэх;<br>• Газрын гадаргуугийн шилжилтийг хянах;<br>• Уурхайн агуулагч чулуулгийн бүрдэл хэсэг, формац ба суналын дагуух хагарлын тэлэлтийг тодорхойлох, илрүүлэх, тайлалт хийх;<br>• Мөргөцөгүүдийн налууд үүссэн чулуулгийн хагарал, бутралын дагуух шилжилт хөдөлгөөнийг хянах;<br>• Мөргөцөгийн налуугийн эсвэл мөргөцөгийн ул хэсгийн товойлт, эвдрэл чулуулгийн хагарал бутралтыг хянах;<br>• Уурхайн хүрээн дэх ус нэвчилт, усны түвшин өсөлтийг хянах, удирдах;<br>• Ашиглах боломжтой хамгийн тохиромжтой хяналтын хэрэгслийг сонгох;<br>• Хэмжилтийн дэвшилтэд арга техникүүд болох (жишээ нь EDM болон GPS-ийн түвшин тогтоох эсвэл фотограмметрийн шинжилгээ судалгааны аргачлал).<br>• Чулуулгийн хагарал эсвэл чулуулгийн томоохон гулсалт, бутралтын хоорондох шилжилтийн хяналтын зүү, призм хяналтын экстенсометр<br>• Цооногийн налуу хазайлт хэмжигч инклинометр ба экстенсометр хэмжилт;<br>• Мөргөцөгийн болон уурхайн ханаы налуугийн хөдөлгөөнийг миллиметрээс бага нарийвчлалтайгаар хэмжихийн тулд газар дээр суурилсан радар хэмжигч аппликэйшн ашиглах; - |

| | |
|---|---|
| | • Ил уурхайн олборлолтын үйл явцад газрын гүний хөдөлгөөн, хазайлтыг хянах хэмжилтийн InSAR хэрэгсэл ашиглах. -<br>• Геотехникийн мониторингийн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлалт хийх системчилсэн ажлын болон системийн арга аргачлалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх;<br>• Ground Defromation Monitoring Plan буюу Газрын хэвлийн дефромацийн хяналтын төлөвлөгөөг боловсруулах<br>**Ажлын Багц №18**<br>**Уурхайн геотехникийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлийг бууруулах, удирдах**<br>• Аюулыг тодорхойлох: Байж болох бүх геотехникийн аюулыг тодорхойлж жагсаалт гаргах<br>• Эрсдэлийн үнэлгээ хийх: бүх аюул эрсдэлийн хувьд байж болзошгүй эрсдэлийн үйл явдлыг тодорхойлж жагсаалт гаргах<br>• Чулуулгийн үүсэж болзошгүй аюул эрсдэлийг таних, тодорхойлох /чулуулгийн масс, эвдрэлийн зэрэг үр нөлөөг ойлгон тодорхойлж уурхайн зураг төсөлд тусгах, уялдуулах;<br>• "Дунд" болон “Өндөр” үнэлгээтэй бүх эрсдэлт үйл явдлын Critical Controls буюу Критикал хяналтыг боловсруулах (үүсч болох хамгийн өндөр эрсдлүүд);<br>• Критикал эрсдлүүдэд Critical Control Plans буюу Критикал хяналтын төлөвлөгөө болон Critical Control Verifictions буюу Криктикал эрсдлийн хяналтын баталгаажуулалтыг бэлтгэх;<br>• Шаардлагатай эрсдэлийн удирдлагын менежментийн арга аргачлал хэрэгслийг боловсруулж, нэвтрүүлэх;<br>• Чулуулгийн массын эвдрэлийг мэдээлэх протокол боловсруулах;<br>• Хананы налуугийн эвдрэлийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн эрсдэлийн үнэлгээний удирдамжийг боловсруулах;<br>• Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн эрсдэлийн түвшин буюу геотехникийн аюулын түвшинг тодорхойлох;<br>• Эрсдэл болон аюулыг таних үйл ажиллагааны түвшинд хийгдэх өөрчлөлтийг практик болон үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой найдвартай "өөрчлөх хүчин зүйлсийг" тодорхойлох;<br>• Эрсдэлийн удирдлагын түвшин бүрд үзүүлэх "эрсдэл бууруулах систем" болон эрсдэлийн хяналтын стратеги буюу (TARP) систем боловсруулах, нэвтрүүлэх<br>• Эрсдэлийн удирдлагын баримт бичиг, нарийвчлан тодорхойлсон ажлуудын харилцааны журам боловсруулах;<br>• Эрсдэлийн удирдлагын тогтолцооны сургалтыг захиалагчаас нэр дэвшүүлсэн ажилтнуудыг сургах;<br>• Газрын гүний тогтворгүй байдлын талбайн судалгаа явуулах протокол боловсруулах;<br><br>**Ажлын Багц №19**<br>**Уурхайн хаалтын геотехник** |

| | |
|---|---|
| | • Уурхайн хаалттай холбоотой урт хугацааны геотехникийн бүх асуудлуудыг хянаж төлөвлөх;<br>**Ажлын Багц №20**<br>**Газрын гүний хөдөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөө**<br>• Уурхайн талбарын газрын гүний хөөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;<br>**Ажлын Багц №21**<br>**Эрдэнэт үйлдвэрт ашиглах геотехникийн техник технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, программ хангамж, системийг тодорхойлох**<br>• Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн үйл ажиллагаанд геотехникийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах техник, технологийн жагсаалтыг гаргах.<br>• Инженер техникийн ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах геотехникийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, программ хангамж, системийг тодорхойлж жагсаалт гаргах<br>**Ажлын Багц №22**<br>**Геотехникийн тайлагналтын систем**<br>• Геотехникийн асуудлаар өдөр тутмын, долоо хоног бүрийн сар бүрийн болон жил эцсийн тайлангийн иж бүрэн протокол боловсруулах;<br>**Ажлын Багц №23**<br>**Геотехникийн сургалтууд**<br>• Геотехникийн инженерчлэлийн бүхий л чиглэлээр одоогийн болон ирээдүйн геотехникийн инженер/геологич, уурхайн инженерийн ур чадвар, чадавхыг нэмэгдүүлэхийн тулд сургалтын курс, зөвлөх ментор хөтөлбөрүүдийг хөгжүүлэх.<br>• Инженер/геологичдод зориулсан геотехникийн инженерийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, курсуудыг тодорхойлох;<br>**Ажлын Багц №24**<br>**Геотехникийн инженеринг нэгжийн байгууллагын бүтэц чиг үүрэг /хэлтэс нэгжийн зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжүүлэлт/**<br>• Уурхайн геотехникийн хэлтэст хамгийн тохиромжтой бүтцийг тодорхойлох;<br>• Геотехникийн инженерүүд үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бүх геотехникийн систем, хэрэгслийг тодорхойлох;<br>• Геотехникийн инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын модулиудыг зохион байгуулах<br>**Ажлын Багц №25**<br>**Геотехникийн технологийн инноваци, судалгаа хөгжлийн төслүүдийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт**<br>• Ил уурхайд нэвтрүүлэх боломж бүхий, зах зээлд бэлэн ашиглагдаж туршигдсан эрсдлийн үр нөлөөгүй технологийг тодорхойлох;<br>• Ил уурхайгаас их дээд сургуулиудтай геотехникийн сургалт судалгааны шинж чанартай төслүүд дээр хамтран ажиллах боломжыг тодорхойлохын зэрэгцээ ажлын байран дахь залуу инженерүүдийг хөгжүүлэх; |

<table>
<tr><td></td><td>
Ажлын Багц №26
Геотехникийн инженер техникийн ажилтнуудыг олон улсын туршлага судлуулах, сургах, ажлын байран дахь интерншип хөтөлбөр хэрэгжүүлэх<br>
• Уурхайн талбар дахь ажлын байрны сургалт, менторшип хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зохион байгуулах<br>
• Австралид геотехникийн инженерийн чиглэлээр олон улсын богино хугацааны сургалт зохион байгуулах;<br>
• Геотехникийн инженер техникийн ажилчдыг олон улсын (Австрали гэх мэт) уурхайн айлчлал зохион байгуулж, тэдгээр уурхайд ашиглагдаж байгаа сайн туршлагыг судлах, таних мэдэх;<br>
• Ахисан түвшний мэргэшсэн мэргэжилтнүүдийн сургалт шаардлагатай тохиолдолд тэнхимийн болон онлайн технологиор сургалтыг зохион байгуулах; (Сургалтын зардал, олон улсын нислэгийн зардлууд тухай бүр захиалагч талаас шийдвэрлэх)
Ажлын Багц №27
Ажлын онцгой нөхцөл
• Ил уурхайд барьж байгуулахаар төлөвлөсөн конвейерийн системийн эргэн тойрон дахь мөргөцгийг бэхжүүлэлтийн зөвлөгөө зөвлөмж өгөх:<br>
• Конвейерийн туузан дамжуулагчийн системийн дээд доголуудын ажлын тавцанг хүчитгэхэд тохиромжтой аргуудыг тодорхойлох, зөвлөмж гаргах;
</td></tr>
<tr><td>2.4 Бусад шаардлагууд</td><td>
Гүйцэтгэгч нь гүйцэтгэх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай байна.<br>
Гүйцэтгэгч болон хамтрагч нь тухайн улсынхаа Татварын болон бусад өр төлбөргүй байх.<br>
Дээрхээс бусад техникийн шаардлага, арга аргачлал нь Монгол Улс болон Олон улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, дүрэмд нийцсэн байна.<br>
Гүйцэтгэгч нь гүйцэтгэх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөц, ур чадвар, туршалага бүхий мэргэжилтэн экспертүүдтэй байна. Үүнд:
<table>
<tr><th>Голлох мэргэжилтнүүдийн албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Голлох мэргэжилтнүүдийн мэргэшил, туршлага, тавигдах шаардлага</th><th>Ажиллах хүн-сар</th></tr>
</table>
</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Багийн ахлагч | 1 | Багийн ахлагч нь 25-аас доошгүй жил уул уурхайн ашиглалт, техник технологи, чулуулгийн физик механик, геотехникийн инженеринг, уул уурхайн төслийн менежмент чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, зураг төсөл ТЭЗҮ боловсруулан, зөвлөх үйлчилгээ, гүйцэтгэгчээр ажиллаж байсан туршлагатай байх.<br>- Уул уурхай болон геотехнийкийн инженерийн мэргэжилээр магистр болон PhD боловсролын зэрэгтэй байх.<br>- Олон улсын уул уурхайн салбарт чулуулгийн физик механикийн болон олборлолтын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчны болон олон улсын хууль журам гэрээ хэлэлцлэлийн талаар ажиллаж байсан мэдлэг туршлагатай байх.<br>- Хувийн ур чадвар сайтай баг удирдах, төсөл хэрэгжүүлэх чадамжтай, уул уурхайн зураг төсөл, систем нэвтрүүлэх, судалгааны ажлыг удирдан зохион байгуулах туршлагатай байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх эсвэл орчуулагчтай ажиллах чадвартай байх. | 6 - 12 сар | |
| | | Багийн дэд ахлагч | 1 | Багийн дэд ахлагч нь 15-аас доошгүй жил уул уурхайн ашиглалт, техник технологи, чулуулгийн физик механик, геотехникийн инженеринг, түүний дотор геотехникийн зураг төсөл, судалгаа, уурхайн талбарт | 6 - 12 сар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | геотехникийн инженерингийн чиглэлээр 10-аас доошгүй ажилласан туршлагатай байх.<br>- Уул уурхайн инженеринг, менежмент болон Геотехникийн инженерингийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Аливаа даалгаварыг түргэн хугацаанд биелүүлэх, төслийн баг удирдах, зохион байгуулах ур чадвар сайтай байх.<br>- Олон улсын төслүүдэд Геотехникийн инженеринг, төслийн менежмент, хэрэгжүүлэлтээр ажиллаж байсан туршлагатай байх<br>- Аман болон бичгийн англи, монгол хэлний өндөр ур чадвартай байх ажлын талбарт орчуулга хийх эсвэл орчуулагчтай ажиллах чадвартай байх. | |
| | | Ил уурхайн геотехникийн ерөнхий инженер | 1 | 10-аас дээш жил ил уурхайн зураг төсөл, геотехникийн зөвлөх үйлчилгээ, үзүүлэх чиглэлээр ажилласан туршлагатай ил уурхайн ашиглалтын систем, эрсдлийн удирдлага, геотехникийн технологийн процессууд тоног төхөөрөмж, програм хангамж, өгөгдөл боловсруулалт, төлөвлөлтийн үнэлгээ судалгааны талаар өргөн мэдлэг туршлагатай байх.<br>-Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлагатай ажиллах , Монгол улсын иргэн бол давуу тал болно.<br>- Аман болон бичгийн монгол болон англи хэлний өндөр ур чадвар мэдлэгтэй байх.<br>- Уул уурхайн геотехникийн | 3 - 6 сар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | инженер, уурхайн удирдлага, ашиглалтын технологийн мэргэжлээр бакалавр/магистр боловсролын зэрэгтэй байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх эсвэл орчуулагчтай ажиллах чадвартай байх. | |
| | Ил уурхайн геотехникийн инженер (Өгөгдлийн сан бүрдүүлэх, боловсруулалт) | 2 | Уурхайн чулуулаг, механик, геотехникийн инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Уурхайн геотехникийн техникч, инженерээр ажилласан туршлагатай ил уурхайн ашиглалтын хайгуулын геотехникийн хэмжилтийн технологийн процессууд тоног төхөөрөмж, өрөмдлөгийн дээжийн хэмжилт, програм хангамж, өгөгдөл мэдээллийн сан бүрдүүлэх мэдлэг туршлагатай байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх эсвэл орчуулагчтай ажиллах чадвартай байх. | 3 - 6 сар |
| | Ил уурхайн геотехникийн инженер (Геотехникийн модель боловсруулалт, дизайнер) | 2 | Уурхайн чулуулаг, механик, геотехникийн инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Уурхайн геотехникийн дизайнер инженерээр ажилласан туршлагатай ил уурхайн геотехникийн модель боловсруулах процессууд тоног төхөөрөмж, програм хангамж, өгөгдөл мэдээллийн сангийн боловсруулалт, дүн шинжилгээ хийх мэдлэг туршлагатай байх.<br>- Мэргэжлийн Англи | 3 - 6 сар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх эсвэл орчуулагчтай ажиллах чадвартай байх, ажлын байран дахь мэргэжлийн сургалт явуулах чадвартай байх. | |
| | | Ил уурхайн геотехникийн инженер (Геотехникийн мониторинг, хяналт шалгалтын мэргэжилтэн) | 2 | Уурхайн чулуулаг, механик, геотехникийн инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Уурхайн геотехникийн мониторингийн инженерээр ажилласан туршлагатай ил уурхайн геотехникийн моделийн шинжилгээ, мониторингийн процессуудыг удирдах тоног төхөөрөмж,програм хангамж, өгөгдөл мэдээллийн сангийн чанарын хяналт, дүн шинжилгээ хийх мэдлэг туршлагатай байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх, ажлын байран дахь мэргэжлийн сургалт явуулах чадвартай байх. | 3 - 6 сар |
| | | Структурийн геологич | 1 | - Геологийн болон ордын структурын хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.<br>- Геологийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх, ажлын байран дахь мэргэжлийн сургалт явуулах чадвартай байх. | 6 - 12 сар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Гидрогеологич | 1 | - Гидрогеологийн хайгуул, уурхайн олборлолтын үеийн хайгуул, уурхайн усны урсацын судалгааны шинжилгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх.<br>- Гидрогеологийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх, ажлын байран дахь мэргэжлийн сургалт явуулах чадвартай байх. | 6 - 12 сар | |
| | Ил уурхайн төлөвлөлтийн, зураг төслийн инженер | 1 | Уул уурхайн ашиглалтын технологийн мэргэжлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Уурхайн блок модель боловсруулах, анализ дүн жилгээг тооцоолох, хянах аудитын үйлчилгээ, тооцоо судалгааны чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай дээрх чиглэлээр мэргэшсэн байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх, ажлын байран дахь мэргэжлийн сургалт явуулах чадвартай байх. | 6 - 12 сар | |
| | Маркшейдер | 1 | Маркшейдрийн ажил үйлчилгээ судалгааны чиглэлээр ажилласан туршлагатай байх.<br>- Маркшейдрийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>- Мэргэжлийн Англи Монгол хэлний мэдлэгтэй байх, ажлын талбарт орчуулга хийх, ажлын байран дахь мэргэжлийн | 6 - 12 сар | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сургалт явуулах чадвартай байх. | |
| | Ажлын байран дахь мэргэжлийн орчуулагч | 2 | -Англи хэлний багш, орчуулагч, мэргэжлийн орчуулагч мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.<br>-Уул уурхай хөгжүүлэлт, зөвлөх үйлчилгээ олборлолтын үеийн үйл ажиллагаанд админ эсвэл орчуулагчаар ажиллаж байсан туршлагатай<br>Уул уурхайн менежмент, олборлолт, геологи, геотехникийн үйл ажиллагаанд орчуулагчаар ажиллаж байсан | 6 - 12 сар |

| **ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ТАЙЛАН** | |
|---|---|
| **3.1 Ажлын хяналт, шалгалт** | Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн удирдлага болон Ерөнхий геологич/уурхайчин болон түүний төлөөлөгч Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн холбогдох нөхцөл шаардлагын хүрээнд байгуулж гарын үсэг зурсан гэрээний дагуу шууд хяналт тавина.<br>Эрдэнэт үйлдвэрийн ил уурхай нь Гүйцэтгэгч/Зөвлөхийн судалгааны ажлыг шаардлагатай үед хүссэн үедээ хянаж, ажлын гүйцэтгэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл авах эрхтэй.<br>Гүйцэтгэгч нь Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн төлөөлөгчийг ямар нэгэн саадгүй хяналт шалгалт хийх боломжоор хангана.<br>Гүйцэтгэгч нь олон улсад итгэмжлэгдсэн геотехникийн зөвлөх инженерийн багаар ажлыг баталгаажуулж хэрэгжүүлнэ.<br>Мэдээ, мэдээллийг гэрээний дагуу нууцалж, зөвхөн энэхүү гэрээнд заасан эрх бүхий шинжээчийн зөвшөөрөл, Эрдэнэт үйлдвэрийн даалгаврын дагуу бусдад үзүүлэх, өгөх, гуравдагч этгээдэд танилцуулах ба Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн цех хяналт шалгалт, зөвшөөрлийг хариуцна. |
| **3.2 Техникийн даалгавар, Тайлан материал хүлээлгэн өгөх** | Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн цехээс баталсан хуваарь, холбогдох гэрээ, техникийн даалгаврын дагуу хянана.<br>Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн удирдлагын зүгээс Гүйцэтгэгчийн ажлыг шаардлагатай үед хүссэн үедээ шалгаж, ажлын гүйцэтгэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл авах эрхтэй.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхай цех нь гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд шууд хяналт тавина.<br>Ажлын явц тус бүрээр явцын, завсрын болон гүйцэтгэлийн тайлангуудыг тухайн ажил дууссан даруйд ил уурхайд хүргүүлнэ.<br>Тайланг лабораторийн шинжилгээний үр дүнгийн төрөл, аргачлал, хайгуулын дээж авах бүх үе шатанд хийгдсэн лабораторийн шинжилгээний |

| | |
|---|---|
| | хэвлэмэл үр дүнг заасан хугацаанд Эрдэнэт үйлдвэрийн ил уурхай, төслийн удирдагчид ирүүлнэ. Ингэхдээ тоон болон цахим хэлбэрээр хавсарган хүргүүлнэ.<br>Шинжилгээний хариу гарсан даруйд дижитал болон цаасан хэлбэрээр хариуцах мэргэжилтнүүд лүү илгээнэ. Хэвлэсэн үр дүн нь албан ёсны тамга, гарын үсгээр баталгаажсан байх ба 2 хувь байх ёстой.<br>Хэвлэсэн үр дүнг өгөгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор үйлчлүүлэгчид хүргэх ёстой. Үр дүнг тогтмол хүргүүлэхтэй холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна.<br>Судалгаа шинжилгээний үр дүн, боловсруулах ажлын чанарын хяналт, чанарын баталгаажуулалтын ажлын тайланг олон улсын болон Монгол Улсын стандарт, дүрэм журмын дагуу гаргаж, бүх тайланг Монгол (үндсэн хэл), Англи (заавал) хэлээр бүрдүүлнэ. Тайлан тус бүр 3 хувь, электрон болон цаасан тайланг хэвлэж бэлтгэсэн байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай нь тайлангийн агуулгад шаардлагатай нэмэлт мэдээлэл, өөрчлөлтийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй ба явцын шалгалтыг Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн холбогдох мэргэжилтнүүд туршилт хийж байгаа талбайд биечлэн гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь холбогдох гэрээнд заагаагүй нэмэлт зардлыг Эрдэнэт үйлдвэрийн Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс лүү нэхэмжлэхийг хүргүүлнэ.<br>Эрдэнэт үйлдвэрийн ил уурхай нь шаардлагатай үед хэдийд ч Гүйцэтгэгчийн ажилтай танилцаж, хяналт шалгалт хийх, ажлын гүйцэтгэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл авах эрхтэй.<br>Судалгаа шинжилгээний арга аргачлалын үр дүн, гарсан зардал, хэвлэсэн (хэвлэмэл болон цахим хэлбэрээр хуулбарлан ирүүлсэн) үр дүнг ажлын бүх үе шатанд заасан хугацаанд Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайд хүргүүлнэ.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай нь дараах бичиг баримт, материалын бүрдлийг хүлээн авна.<br>а) Структур, гидрогеологи, геотехникийн судалгаа шинжилгээ, арга аргачлалд тавигдах шаардлага бүхий гарын авлага, заавар,<br>б) Туршилт судалгааны ажлын бүх тоон үр дүн, хэвлэмэл болон цахим хуулбар<br>в) Структур, гидрогеологи, геологи, геотехникийн боловсруулсан загварууд<br>г) Мэдээлэл боловсруулах программ хангамжийг ашиглах сургалт, гарын авлага<br>д) Хэмжилтийн өгөгдөл боловсруулсан үр дүн болон холбогдох материалыг ил уурхайн геотехникийн багт электрон болон хэвлэмэл тайлан хэлбэрээр хадгалан хүргүүлнэ.<br>е) Судалгаа шинжилгээний боловсруулалтын хэрэгслийг, програм хангамжийг ашиглах заавар, өгөгдөл боловсруулах аргын гарын авлага<br>ж) Уурхайн геотехникийн ажлын өдөр, сар, улирал, жилийн тайлангийн аргачлал, загвар.<br>з) Гүйцэтгэгч нь ил уурхайн геологич, гидрогеологич, маркшейдер, геотехникийн инженер гэх мэт геотехникийн мэргэжилтнүүдийг гадаад дотоодын ижил төстэй уурхайнуудад, Эрдэнэтийн ил уурхайд онол, практикийн сургалтуудад хамруулж тайланг хүргүүлнэ.<br><br>***Үе шат №1 -д* тавигдах шаардлага.**<br>1-р шатанд багтсан ажлууд нь уурхайн өнөөгийн байдлыг тодорхойлоход маш чухал хамааралтай бөгөөд түүнд хүрэхийн тулд дараахь зүйлсийг хийх шаардлагатай болно. |

| | |
|---|---|
| | а) Геотехникийн инженерийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн бүхий баг гүйцэтгэх ёстой бөгөөд шаардлагатай гэж үзсэн хугацаанд Эрдэнэтийн уурхайн талбайд ажиллана.<br>б) Тухайн гүйцэтгэгч нь хэрэгжүүлж буй геотехникийн инженерийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтний баг нь дэлхийн томоохон уул уурхайн компаниудтай хамтран ажиллаж, группийн түвшинд (янз бүрийн орчин, харьяалал дахь олон уурхайн талбай) геотехникийн чиг үүргийг удирдах олон улсын арвин туршлагатай байх ёстой.<br>в) Эрдэнэтийн овоо уурхайн одоогийн геотехник, систем, технологи, үйл явцын нарийвчилсан үнэлгээг хийж Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээний тайланг гаргах;<br>г) Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээ нь уул уурхайн геотехникийн инженерчлэлийн практикийг бүхэлд нь хамрах ёстой бөгөөд тодорхой системийн домэйн, эсвэл тусгай өмчийн хэрэглээ, эсвэл тусгай платформ шийдэл, загвар эсвэл системийг хэрэгжүүлэх процесс биш юм;<br>д) Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээний тайлан нь уурхайн талбай дахь геотехникийн практикийн өнөөгийн байдлыг үнэлгээ хийж мэдээллэх, дутагдлуудыг сайжруулах боломжуудыг тодорхойлох;<br>е) Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээ нь Цогц хөтөлбөрт заасан ажлын эхний багцад хийсэн өөрчлөлтүүдийг мэдээллэн тайлагнах ёстой бөгөөд энэ нь ажлын багцуудыг хийж гүйцэтгэх хуваарийн эцсийн хувилбарыг гаргаж тодорхойлон баталгаажуулах явдал юм.<br>ж) Ажлын үр дүнгээр Цогц хөтөлбөрийн дараагийн бүх үе шатуудыг тодорхойлно.<br>з) Цогц хөтөлбөрийн ажлын хамрах хүрээ болон хөтөлбөрийн хуваарийг (янз бүрийн үе шатуудыг хэрэгжүүлэх цаг хугацааны дараалал хувиарыг) шинэчилж, хөтөлбөрийн дараагийн үе шатуудын урьдчилсан төсвийг танилцуулж захиалагчаар батлуулна.<br>**Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээ: Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн геотехникийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлж үнэлэх шинжилгээ.**<br>1. Уурхайн үйл ажиллагааны геотехникийн функцийн өмнө хийгдсэн болон одоогийн чадавхи, зохион байгуулалтыг үнэлэх, хянах;<br>2. Одоогийн ашиглаж байгаа техник техологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, технологиудыг шалгах, үнэлэх<br>3. Уурхайн үйл ажиллагаан дахь циклийн үйл явц бүрийн одоогийн горимуудыг хянаж, шилдэг туршлагад нийцүүлэн зураглах;<br>4. Уурхайн өгөгдлийн сан болон одоо байгаа мэдээллүүдийн өгөгдлийн тайлан, формат, бүрэн бүтэн байдал, тууштай үр ашигтай эсэх, хэрэглэгдэхүүний байдлыг шалгах;<br>5. Ажлын урсгалын шинэчилсэн диаграммд алхам бүрт шаардагдах баримт бичгийн жагсаал гаргах;<br>6. Геотехникийн чиглэлээр ажиллаж байгаа болон холбогдон ажиллах инженер техникийн ажилтнуудын өнөөгийн ур чадварыг тодорхойлж ажлын шаардагдах ур чадварын матрицыг боловсруулах;<br>7. Геотехникийн процессын ажлын өнөөгийн схемийн эмхэтгэх;<br>8. Өнөөгийн уурхайн үйл ажиллагааны геотехникийн хамаарал бүхий үйл явцыг хянаж, орхигдуулж байгаа ажлуудын дүн шинжилгээ хийж, нэмэлт шаардлагатай байгаа ажлуудын зураглалыг хийх;<br>9. Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалахын тулд мэдээллийн сан, тайлангуудын эмхэтгэлийг (хянах) тогтоосон болон шинээр нэвтрүүлэх зөв зохистой форматаар боловсруулах; |

| | |
|---|---|
| | 10. Геотехникийн удирдах болон инженер техникийн ажилтнуудын сургалт, ажлын байран дахь дасгалжуулалтын хэрэгцээг тодорхойлж, хянах, шинэ журмыг хэрэгжүүлэх;<br>11. Шинэ системд үйл явцыг тусгахын тулд геотехникийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг хянах;<br>12. Геотехникийн өрөмдлөгийн хөтөлбөрүүдийг хянах, ажлын горимыг удирдах;<br>13. Уурхайн зураг төсөл, оновчлолын өмнөх тоон загварчлалын ажлыг эргэн харах;<br>14. Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээг харьцуулж, ажлын цар хүрээ, багцалсан ажлуудыг хэрэгжүүлэх үе шатуудыг тохируулах, баталгаажуулах;<br>15. Ажлын багцын бүх техникийн даалгаврын тоймыг боловсруулж хянах, хамрах хүрээг тодорхойлох шинжилгээний үр дүнгээр тодорхойлогдсон зөвлөмжийн дагуу Үе шатуудыг тохируулна: Хамрах хүрээг тодорхойлох шинжилгээний үр дүнгийн дагуу Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаг хугацаа, төсөвт өртгийг үе шат болон ажлын багц тус бүрт нарийвчлан тодорхойлох;<br>16. Геотехникийн цогц хөтөлбөрийн ажлын цар хүрээг эцсийн байдлаар нарийвчлан тодорхойлж хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн удирдлагад танилцуулж ажлын даалгаварыг батлуулах.<br>**Геотехникийн чиглэлээр мөрдөх шаардлагатай Монгол улсын хууль эрх зүй, дүрэм журам, түүнийг хэрэгжүүлж буй Эрдэнэт үйлдвэрийн байгууллагын бүтэц удирдлагын тогтолцооны уялдаа холбоог хянах, үнэлэх**<br>1. Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль, Уурхайн аюулгүй байдлын дүрэм, Тогтвортой хөгжил, Байгаль орчны тухай хууль болон ил уурхайн зураг төсөл боловсруулах, ашиглах, уурхай хаахад анхаарах шаардлагатай геотехникийн хүчин зүйлүүдтэй холбоотой холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмыг хянаж үзэн үйл ажиллагааны горимд уялдуулах.<br>2. Хууль тогтоомж, уурхайн бодлого, дүрэм журмын дагуу аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны менежментийн шилдэг туршлагыг сурталчлах, дэмжих, хэрэгжүүлэх чиглэлээр уурхайн талбайд хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах;<br>**Ил уурхайн хананы налуугийн тоон загварчлалыг боловсруулах**<br>1. Уурхайн хананы налуугийн тогтвортой байдлыг үнэлэхэд тохиромжтой тоон загварчлалын аргыг тодорхойлох;<br>2. Уурхайн талбайд нэвтрүүлэх тоон загварчлалын багц/програм хангамжийг тодорхойлох;<br>3. Тус тоон загваруудыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллах ажлын удирдамжийг боловсруулах:<br>**Орд газрын ан цавшил, уурхайн үндсэн хагаралын бүсүүдийн хяналт, мониторинг**<br>1. Уурхайн хэмжээнд геотехникийн хяналтын системийг суурилуулах ажлыг төлөвлөх, удирдах;<br>2. Ашиглах боломжтой хамгийн тохиромжтой хяналтын хэрэгсэлийг сонгох;<br>3. Хэмжилтийн дэвшилтэд арга техникүүд болох (жишээ нь EDM болон GPS-ийн түвшин тогтоох эсвэл фотограмметрийн шинжилгээ судалгааны аргачлал). |

| | |
|---|---|
| | 4. Чулуулгийн хагарал эсвэл чулуулгийн томоохон гулсалт, бутралтын хоорондох шилжилтийн хяналтын зүү, призм хяналтын экстенсометр<br>5. Цооногийн налуу хазайлт хэмжигч инклинометр ба экстенсометр хэмжилт<br>6. Ground Defromation Monitoring Plan буюу Газрын хэвлийн дефромацийн хяналтын төлөвлөгөөг боловсруулах<br>**Уурхайн геотехникийн эрсдлийг тодорхойлох, эрсдлийг бууруулах, удирдах**<br>1. Аюулыг тодорхойлох: Байж болох бүх геотехникийн аюулыг тодорхойлж жагсаалт гаргах<br>2. Эрсдлийн үнэлгээ хийх: бүх аюул эрсдлийн хувьд байж болзошгүй эрсдэлийн үйл явдлыг тодорхойлж жагсаалт гаргах<br>3. Чулуулгийн үүсч болзошгүй аюул эрсдлийг таних тодорхойлох/чулуулгийн масс, эвдрэлийн зэрэг үр нөлөөг ойлгон тодорхойлж уурхайн зураг төсөлд тусгах, уялдуулах;<br>4. Шаардлагатай эрсдэлийн удирдлагын менежментийн арга аргачлал хэрэгслийг боловсруулж, нэвтрүүлэх;<br>5. Чулуулгийн массын эвдрэлийг мэдээлэх протокол боловсруулах;<br>6. Хананы налуугийн эвдрэлийн эрсдлийг бууруулахад чиглэсэн эрсдлийн үнэлгээний удирдамжийг боловсруулах;<br>7. Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн эрсдэлийн түвшин буюу геотехникийн аюулын түвшинг тодорхойлох;<br>8. Эрсдэл болон аюулыг таних үйл ажиллагааны түвшинд хийгдэх өөрчлөлтийг практик болон үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой найдвартай "өөрчлөх хүчин зүйлсийг" тодорхойлох;<br>9. Эрсдэлийн удирдлагын түвшин бүрт үзүүлэх "хариу эсрдэл бууруулах систем" болон эрсдлийн хяналтын стратеги буюу (TARP) систем боловсруулах нэвтрүүлэх<br>10. Эрсдэлийн удирдлагын баримт бичиг, нарийвчлан тодорхойлсон ажлуудын харилцааны журам боловсруулах;<br>11. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны сургалтыг захиалагчаас нэр дэвшүүлсэн ажилтнуудыг сургах;<br>12. Газрын гүний тогтворгүй байдлын талбайн судалгаа явуулах протокол боловсруулах;<br>**Газрын гүний хөдөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөө**<br>1. Уурхайн талбарын газрын гүний хөөлгөөний хяналтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;<br>**Эрдэнэт үйлдвэрт ашиглах геотехникийн техник технологи, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, програм хангамж системийг тодорхойлох**<br>1. Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн үйл ажиллагаанд геотехникийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах техник технологийн жагсаалтыг гаргах.<br>2. Инженер техникийн ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах геотехникийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, програм ханганм системийг тодорхойлж жагсаалт гаргах<br>**Геотехникийн тайлагналтын систем**<br>1. Геотехникийн асуудлаар өдөр тутмын, долоо хоног бүрийн сар бүрийн болон жил эцсийн тайлангийн иж бүрэн протокол боловсруулах;<br>**Геотехникийн сургалтууд**<br>2. Инженер/геологичдод зориулсан геотехникийн инженерийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, курсуудыг тодорхойлох; |

| | |
|---|---|
| | **Геотехникийн инженеринг нэгжийн байгууллагын бүтэц чиг үүрэг / хэлтэс нэгжийн зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжүүлэлт**<br>1. Уурхайн геотехникийн хэлтэст хамгийн тохиромжтой бүтцийг тодорхойлох;<br>2. Геотехникийн инженерүүд үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бүх геотехникийн систем, хэрэгслийг тодорхойлох;<br>3. Геотехникийн инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын модулиудыг зохион байгуулах<br>**Геотехникийн инженер техникийн ажилтнуудыг олон улсын туршлага судлуулах, сургах, ажлын байран дахь интерншип програм хэрэгжүүлэх**<br>1. Уурхайн талбар дахь ажлын байрны сургалт, менторшип хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зохион байгуулах<br>2. Геотехникийн инженер техникийн ажилчдыг олон улсын уурхайн айлчлал зохион байгуулж, тэдгээр уурхайд ашиглагдаж байгаа сайн туршлагыг судлах, таних мэдэх;<br>3. Ахисан түвшний мэргэшсэн мэргэжилтнүүдийн сургалт шаардлагатай тохиолдолд тэнхимийн болон онлайн технологоор сургалтыг зохион байгуулах; (Сургалтын зардал, олон улсын нислэгийн зардлууд тухай бүр захиалагч талаас шийдвэрлэх) |
| **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА** | |
| **4.1. Ажил эхлэх** | Ажил гүйцэтгэх гэрээний дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын холбогдох удирдлагаар батлагдсан хугацаанд: |
| **4.2. Хугацаа** | Цогц хөтөлбөрийн хамрах ажлын цар хүрээг нарийвчлан үе шат тус бүрээр тодорхойлсон байх ба Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайн удирдлагуудад танилцуулж батлуулна.<br>Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлээр хөтөлбөрийн хийгдэх ажлыг урьдчилан тодорхойлж ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг захиалагч талаар батлуулснаар ажлыг эхлүүлнэ. |

# IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.*

*Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 33.1.5-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.*

*Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.*

1. *Үйлчилгээг гүйцэтгэх хуваарь: **[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]***

   *Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (үйлчилгээ гүйцэтгэж эхлэх хамгийн эхний өдрөөс хойш үйлчилгээ гүйцэтгэж дуусах хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) гүйцэтгэх шаардлагатай. Үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт заасан хугацаанаас өмнө үйлчилгээг гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.*

   *Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**–иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.*

   *Үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон хугацаанаас хойш гүйцэтгэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. *Тусгайлсан нэмэлт шалгуур*

   *Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.*

   *[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ авах тендерийн харьцуулах үнийг хэрхэн тодорхойлох шалгуур үзүүлэлтийг энд бич.*

   *Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.]*

# V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД


Маягт 1 Тендер илгээх маягт ....57

Маягт 2 Тендерийн баталгаа (банкны)....58

Маягт 3 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас) ....59

Маягт 4 Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл ....60

Маягт 5 Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл 60

Маягт 6 Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл....60

Маягт 7 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл....61

Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл....61

## Маягт 1 Тендер илгээх маягт

***[огноо]***

***[Захиалагч байгууллагын нэр]***-д

Манай ***[тендерт оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу зөвлөхөөс бусад үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[30 ба түүнээс дээш хоногийн тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.[4]
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 16.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ болон тухайн үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой зөвлөхөөс бусад үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг,***

***байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***

[4] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "*5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.*" гэж сольж бичнэ үү.

## **Маягт 2  Тендерийн баталгаа (банкны)**

Баталгаа хүлээн авагч: ***[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]***
Огноо: ***[баталгаа гаргасан огноог бичих]***
Дугаар: ***[тендерийн баталгааны дугаар бичих]***
Баталгаа гаргагч: ***[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]***

1. Баталгаа гаргагч нь ***[тендерт оролцогчийн нэр]*** (цаашид "тендерт оролцогч" гэх)-аас ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид "тендер" гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт ***[мөнгөн дүн]***–ийн[5] төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.

2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
   - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид "Тендер хүчинтэй байх хугацаа" гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
   - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
     - 2.2.1. ТШЗ-ны 39 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
     - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
     - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
   - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.

4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.

5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

**[*Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.*]**

*[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]*

[5] Энэ дүн нь ТШЗ-ны 22.1-д заасантай ижил байна.

## Маягт 3 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)

Баталгаа хүлээн авагч: ***[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]***
Огноо: ***[баталгаа гаргасан огноог бичих]***
Дугаар: ***[тендерийн баталгааны дугаар бичих]***
Баталгаа гаргагч: ***[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]***

1. Баталгаа гаргагч нь [***тендерт оролцогчийн нэр***] (цаашид "тендерт оролцогч" гэх)-ийг [***тендер шалгаруулалтын нэр, дугаар***] тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид "тендер" гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт [***мөнгөн дүн***][6] төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валютын төлбөрийн үүрэг хүлээх баталгааг нийт **[мөнгөн *дүн*]** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **[*Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр болон холбогдох бусад мэдээллийг бичих*]** (цаашид "Үнэт цаас" гэх)-г[7] үндэслэн гаргаж байна.

2. Энэхүү баталгааны дагуу Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

   2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид "Тендер хүчинтэй байх хугацаа" гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;

   2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:

      2.2.1. гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
      2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
      2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.

   2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.

4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.

5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

   **[*Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг заана уу.*]**

*[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]*

---

[6] Энэ дүн нь ТШЗ-ны 22.1-д заасантай ижил байна.
[7] Засгийн газрын бонд болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

**Маягт 4** **Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл**

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

**Маягт 5** **Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

| Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | *[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]* |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

**Маягт 6** **Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Маягт 7 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| **Гэрээний нэр** | **Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас** | **Төсөвт өртөг** | **Гэрээ эхэлсэн хугацаа** | **Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр** | **Дуусах хугацаа** |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө]*.

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |
| 8. | Хавсралт<br>- Гэрээний хуулбар<br>- Гэрээ дүгнэсэн акт / үйлчилгээ хүлээлцсэн акт / захиалагчийн тодорхойлолт |

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

## САНАМЖ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж зөвлөхөөс бусад үйлчилгээг гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь үйлчилгээний тодорхойлолтод заагдсан үйлчилгээг гүйцэтгүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн үзүүлэх үйлчилгээнд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн үйлчилгээг гүйцэтгүүлэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Үзүүлэх үйлчилгээ, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолтыг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

**ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

ГАРЧИГ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ....64
НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР .... 64
Тодорхойлолт....64
Тайлбар....65
ХОЁР . ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ.... 65
Үйлчилгээ үзүүлэх....65
Үйлчилгээ үзүүлэх газар....66
Үйлчилгээ эхлэх хугацаа ....66
Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа....66
Үйлчилгээ үзүүлэх хугацааг сунгах....66
Тайлагнах үүрэг ....66
Ажилтныг солих ....66
Даатгал....66
Гүйцэтгэлийн баталгаа....67
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ .... 67
Хүлээн авах ....67
Шалгалт,туршилт ....67
Гэрээний үнэ ....67
Төлбөр төлөх....67
Өмчлөх эрх ....68
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА, ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ҮНДЭСЛЭЛ .... 68
Баталгаат хугацаа....68
Доголдол илрүүлэх....68
Доголдол арилгах ....68
Алданги....68
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал ....69
ТАВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ.... 69
Гэрээ цуцлах үндэслэл ....69
Гэрээ цуцлах журам....69
Гэрээ цуцалсны үр дагавар ....70
ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛ.... 70
Төлөөлөгч ....70
Туслан гүйцэтгэгч....70
Оюуны өмч ....70
Нууцлал ....70
Мэдэгдэл....70
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ....71
Маргаан шийдвэрлэх....71
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ....72
ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ....73

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

**Тодорхойлолт**

1.1. Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.1.1. “Үйлчилгээ” гэж үйлчилгээний тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж Үйлчилгээний тодорхойлолтод заасан үндсэн үйлчилгээтэй салшгүй холбоотой бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Үйлчилгээ үзүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Баталгаат хугацаа” гэж гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлсэн үйлчилгээг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад илэрсэн доголдлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцах хугацааг;

1.1.8. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага гаргах Иргэний хуульд заасан хугацааг;

1.1.9. “Хоног” гэж хуанлийн хоногийг;

1.1.10. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.11. “Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Үйлчилгээ үзүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.12. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

**Тайлбар**

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад хэрэглэхгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд бусад тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас гэрээний хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР . ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

**Үйлчилгээ үзүүлэх**

2.1. Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээний тодорхойлолтод заасан үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд гүйцэтгэнэ.

2.2. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний дагуу үйлчилгээ, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд ажилтан, тоног төхөөрөмж, бараа, материал зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн жишигт нийцүүлэн гүйцэтгэнэ.

2.5. Үйлчилгээ үзүүлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.

2.6. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Үйлчилгээ үзүүлэх газар**

2.7. Үйлчилгээ, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Үйлчилгээ эхлэх хугацаа**

2.8. Үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд эхлүүлнэ.

**Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа**

2.9. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгч тэмдэглэл (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

**Үйлчилгээ үзүүлэх хугацааг сунгах**

2.10. Үйлчилгээ үзүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үйлчилгээ үзүүлэх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргаж болно.

2.10.1. Захиалагч ГЕН-ийн 2.6-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй;

2.10.2. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд үзүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.10.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй.

2.11. Захиалагч ГЕН-ийн 2.10-т заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

**Тайлагнах үүрэг**

2.12. Үйлчилгээний тодорхойлолтод үе шатны тайланг ирүүлэхээр заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүргүүлнэ.

**Ажилтныг солих**

2.13. Ажилтан нас барсан, тэтгэвэрт гарсан, хөдөлмөрийн чадвараа алдсан, гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн ажилтантай адил эсхүл илүү чадвар, туршлага бүхий хүнийг нэн даруй авч ажиллуулна.

2.14. ГЕН-ийн 2.13-т зааснаас бусад тохиолдолд ажилтны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй.

**Даатгал**

2.15. Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан эрсдэлд хамаарах даатгалд өөрийн зардлаар даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчид ирүүлнэ.

2.16. Үйлчилгээ үзүүлэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол Захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Үйлчилгээ үзүүлэгчээс гаргуулна.

**Гүйцэтгэлийн баталгаа**

2.17. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

2.18. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.18.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.18.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.18.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.19. Үйлчилгээ үзүүлэгч нь гүйцэтгэлийн баталгааг Захиалагчаас шаардсан хугацаанд, хуульд заасан хэлбэрээр холбогдох маягтын дагуу ирүүлнэ.

2.20. Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийн хангуулсан нь Үйлчилгээ үзүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.21. ГЕН-ийн 2.11-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

**Хүлээн авах**

3.1. Захиалагч нь үйлчилгээг ГТН-д заасны дагуу хүлээн авч тэмдэглэл (акт) үйлдэнэ.

**Шалгалт,туршилт**

3.2. Үйлчилгээ, дагалдах үйлчилгээ нь тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд үйлчилгээ, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний доголдлыг арилгана.

3.5. Үйлчилгээг хүлээн авсан болон шалгалт туршилт хийсэн нь Захиалагчийн доголдолтой холбогдуулж шаардлага гаргах эрхийг хязгаарлахгүй.

**Гэрээний үнэ**

3.6. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

**Төлбөр төлөх**

3.7. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

3.8. Захиалагч нь үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувийг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.9. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

**Өмчлөх эрх**

3.10. Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, тайлан болон бусад баримт бичиг нь Захиалагчийн өмч байна. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичгийн хуулбарыг авч үлдэж болох бөгөөд энэ тохиолдолд ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд ашиглана.

## ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА, ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ҮНДЭСЛЭЛ

**Баталгаат хугацаа**

4.1. Баталгаат хугацаа шаардаж болно. Баталгаат хугацаа шаардах бол баталгаат хугацааг ГТН-д заана.

4.2. Баталгаат хугацааг ГТН-д заасан бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа заагаагүй бол үйлчилгээг хүлээн авснаас хойш Иргэний хуульд заасан хугацаанд Захиалагч гомдлын шаардлага гаргаж болно.

4.3. Захиалагч нь баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн доголдолтой үйлчилгээний доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.

**Доголдол илрүүлэх**

4.4. Захиалагч үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж илэрсэн доголдлын талаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ.

4.5. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор, шалгалт, туршилт хийж болно.

**Доголдол арилгах**

4.6. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

4.7. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.8. Үйлчилгээ үзүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.

4.9. Захиалагчийн гаргасан зардлыг Үйлчилгээ үзүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

**Алданги**

4.10. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд үзүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.11. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

**Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**

4.12. Үйлчилгээ үзүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

4.13. Үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.14. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.15. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Үйлчилгээ үзүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч ГЕН-ийн 2.10-д заасан хүсэлт гаргаж болно.

4.16. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн болох нь нотлогдсон тохиолдол энэ нь үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах эсхүл үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн зөрчилд хүлээлгэх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.

## ТАВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

**Гэрээ цуцлах үндэслэл**

5.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн дагуу мэдэгдэл хүлээн авч тогтоосон хугацаанд доголдлыг арилгаагүй;

5.1.2. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувьд хүрсэн;

5.1.3. Үйлчилгээ үзүүлэгч нь тендерт оролцох буюу үйлчилгээг үзүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон нь шүүх болон холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

5.1.4. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн.

5.2. Үйлчилгээ үзүүлэгч дараах үндэслэлээр гэрээг цуцлах эрхтэй:

5.2.1. Захиалагч нь ГТН-д заасан хугацаанд төлбөр төлөөгүй;

5.2.2. Төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөр төлөөгүй;

5.2.3. Захиалагчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувьд хүрсэн.

**Гэрээ цуцлах журам**

5.3. ГЕН-ийн 5.1-5.2-д заасан гэрээ цуцлах үндэслэл бүрдсэн тохиолдолд Гэрээ цуцлах мэдэгдлийг нөгөө талд бичгээр өгнө.

5.4. Гэрээ цуцлах мэдэгдэлд гэрээг цуцлах болсон үндэслэл, үр дагаврыг тусгасан байна.

**Гэрээ цуцалсны үр дагавар**

5.5. Гэрээ цуцлагдсан тохиолдолд нөгөө талд учирсан хохирлыг үүрэг зөрчсөн тал Иргэний хуульд заасан журмын дагуу арилгана.

## ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛ

**Төлөөлөгч**

6.1. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачлагаар өөрчилж болно.

6.2. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

6.3. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

6.4. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр гэрээ баталгаажуулах маягтад заасан болон өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

**Туслан гүйцэтгэгч**

6.5. Үйлчилгээ үзүүлэгч нь нийт ажлын 10 (арав) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

**Оюуны өмч**

6.6. Үйлчилгээг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

**Нууцлал**

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

**Мэдэгдэл**

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9-д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл баталгаат шуудангаар нөгөө талын гэрээ баталгаажуулах маягтад заасан хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шуудангийн төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан тэмдэглэлийг үндэслэн.

6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14. ГЕН-ийн 6.13-т заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

**Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

6.15. ГЕН-ийн 2.11-т заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

**Маргаан шийдвэрлэх**

6.17. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг зорино.

6.18. Маргааныг зөвшилцөж шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаа: ***[Гэрээ байгуулагдсан өдрөөс 2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл]***

Үйлчилгээг үе шаттай үзүүлэх бол,

Үйлчилгээ үзүүлэх үе шатны хугацаа: ***[огноо бичих]***

ГЕН 2.7 Үйлчилгээ, дагалдах үйлчилгээ үзүүлэх газар:

***Багц-1: Орхон аймаг, Баян-Өндөр сум, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ***

ГЕН 2.8 Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: ***[ Гэрээ байгуулагдсан өдөр ]***

ГЕН 2.9. Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа: ***[2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл]***

Үйлчилгээг хэсэгчилсэн байдлаар хүлээлгэн өгөх бол,
үе шатны хугацаа: ***[огноо бичих]***

ГЕН 2.12. Тайлан ирүүлэх хугацаа: ***[огноо бичих]***

Үе шатны тайлан ирүүлэх бол,
Тайлан ирүүлэх үе шатны хугацаа: ***[огноо бичих]***

ГЕН 2.15. Даатгал: ***[Үзүүлэх үйлчилгээний онцлогийг харгалзан гарч болох даатгалын эрсдэлийг тодорхойлно.]***

ГЕН 3.1 Үйлчилгээг хүлээн авах нөхцөл, журам: ***[Үйлчилгээ хүлээн авах нөхцөл, журмыг бичих]***

ГЕН 3.7 Төлбөр төлөх хугацаа: ***[огноо бичих]***

Төлбөрийг хэсэгчлэн төлөх бол,
Төлбөр төлөх үе шатны хугацааг: ***[Урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 30 хүртэл хувийг урьдчилан олгож болно]***

ГЕН 3.10. Баримт бичиг ашиглах хүрээ: ***[Үйлчилгээ үзүүлэх явцад ашигласан болон бий болгосон баримт бичгээс үйлчилгээ үзүүлэгчийн ашиглах хүрээг тодорхой бичих]***

ГЕН 4.1. Үйлчилгээний баталгаат хугацаа: ***[тоо бичих]***

***Жишээ нь: 12 сар***

ГЕН 4.10. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх алданги:

Алданги тооцох эсэх: **"Тийм"**

Алдангийн хувь: ***Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь.***

ГЕН 4.11. **Захиалагчийн төлөх алданги:**
Алдангийн хувь: ***Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь.***

# ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

***[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]*** гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **[үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид "үйлчилгээ үзүүлэгч" гэх) нь Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлтэйгээр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх (цаашид хамтад нь "Үйлчилгээ" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу үзүүлэх Үйлчилгээний үнэ нь ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Үйлчилгээ үзүүлэгч ***[Үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - 3.2. Үйлчилгээ үзүүлэгч тендер илгээсэн маягт;
   - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
   - 3.6. Үйлчилгээний тодорхойлолт;
   - 3.7. Үйлчилгээ гүйцэтгэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:
     Гар утас:
     Цахим шуудан:

   - 4.2. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:
     Гар утас:
     Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]______________

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____________

## **Гүйцэтгэлийн баталгааны маягт** (Банкны)

Баталгаа хүлээн авагч: ***[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]***
Огноо: ***[баталгаа гаргасан огноог бичих]***
Дугаар: ***[баталгааны дугаар бичих]***
Баталгаа гаргагч: ***[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]***

1. ***[Үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]*** (цаашид "**Үйлчилгээ үзүүлэгч**" гэх) нь ***[үйлчилгээний товч тодорхойлолт]***-ыг үзүүлэх зорилгоор ***[Гэрээний нэр ба дугаарыг бичих]*** (цаашид "гэрээ" гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.

2. Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт ***[мөнгөн дүн]***–ийн төлбөрийн үүрэг хүлээж ***[баталгааны дүн тоогоор] [дүн үсгээр]*** баталгаа гаргаж байна.

3. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.

4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

5. Энэхүү баталгаа нь ***[огноо бичих]*** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:
Албан тушаалын нэр:
Албан тушаалтны гарын үсэг:
Байгууллагын тамга,тэмдэг
Огноо:
Хаяг:

**Гүйцэтгэлийн баталгааны маягт**

(Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)

Баталгаа хүлээн авагч: ***[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]***
Огноо: ***[баталгаа гаргасан огноог бичих]***
Дугаар: ***[баталгааны дугаар бичих]***
Баталгаа гаргагч: ***[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]***

1. ***[Үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]*** нь (цаашид "**Үйлчилгээ үзүүлэгч**" гэх) [***үйлчилгээний товч тодорхойлолт***]-ыг үзүүлэх зорилгоор ***[Гэрээний нэр ба дугаарыг бичих]*** (цаашид "гэрээ" гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.

2. Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт ***[мөнгөн дүн]***–ийн төлбөрийн үүрэг хүлээж ***[баталгааны дүн тоогоор] [дүн үсгээр]*** нэрлэсэн үнэ бүхий ***[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]*** (цаашид "Үнэт цаас" гэх)-г[8] үндэслэн баталгаа гаргаж байна.

3. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлөх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Үнэт цаасыг Захиалагчийн нэр дээр шилжүүлнэ.

4. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

5. Энэхүү баталгаа нь ***[огноо бичих]*** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Эрх бүхий албан тушаалтны нэр:
Албан тушаалын нэр:
Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:
Байгууллагын тамга:
Огноо:
Хаяг:

[8] Засгийн газрын бондын болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь гэрээний хэрэгжиж дуусах хугацаанаас 3-аас доошгүй сарын дараа байна.

**ТЕНДЕРИЙН УРИЛГА**

Огноо : ***[2022 оны 10 сарын 04 ]***

Тендер шалгаруулалтын нэр: ***[Эрдэнэтийн ил уурхайд геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх ажил]***

Тендер шалгаруулалтын дугаар: ***[ЭҮТӨҮГ/202202044]***

***"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ*** нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг ***Эрдэнэтийн ил уурхайд геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх ажил***–ыг үзүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***Багцгүй***

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй ба ***14,250,000.0 /арван дөрвөн сая хоёр зуун тавин мянга/*** төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг ***2022 оны 11 сарын 04-ний өдрийн 09 цаг 00 минутаас*** өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг ***2022 оны 11 сарын 04-ний өдрийн 09 цаг 15 минутад*** зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***"Эрхтэй"***

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: ***"Үгүй"***

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

**Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал-1, "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын**
**Ерөнхий захиргааны 2-р байр, 3 дугаар давхар, 348 тоот**
**Утас: 75773598**
**Цахим хаяг: www.tender.gov.mn**